

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болсон жилийн

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН
ОХИН КОМПАНИУД

Агуулга

	Хуудасны №
Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	2
Байгууллагын талаарх мэдээлэл	3
Хараат Бүс Аудиторын тайлан	4-8
Нэгтгэсэн Санхүүгийн Тайлангууд	9-15
Нэгтгэсэн Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	9
Нэгтгэсэн Санхүүгийн байдлын тайлан	10-11
Нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан	12-13
Нэгтгэсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	14-15
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд	16-77
Тайлагнагч аж ахуй нэгж	16
Өөдрөг төсөөлөл	17
Нэгтгэсэн тайлан бэлтгэсэн үндэслэл	17-18
Шинэ стандарт, тайлбар ба нэмэлт өөрчлөлтүүд	18-19
Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл	20-23
Санхүүгийн хэрэгслүүд –Эрсдэлийн Удирдлага	24-28
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулгууд	29-58
Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй	59-71
Сегментийн тайлагнал	72-72
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө	73-74
Холбоотой талууд	75-76
Нэгтгэсэн санхүүгийн Тайлангийн нэмэлт тодруулгууд	77

**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**


Энэхүү тайлангийн 4-8 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Шарын Гол" Хувьцаат Компанийн болон түүний охин компаниудын (нийтэд нь "Групп" гэх) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь харуулах зорилгоор хийгдсэн болно.

"Групп"-ийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа СТОУС, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Групп"-ийн 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.




Б.ХИШИГСҮХ
Ерөнхий
Захирал


М.МӨНХБОЛОР
Санхүү Эрхэлсэн Дэд
Захирал

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2019 оны 04 дугаар сарын 04-ний өдөр

“Шарын Гол” ХК болон охин компани
Байгууллагын талаарх мэдээлэл

Төлөөлөн Удирдах Зөвлөл	Г.Хулан (ТУЗ-ийн дарга)-Хараат бус Б.Батбаатар (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Ж.Эрдэмбилэг(ТУЗ-ийн гишүүн)-Хараат Ө.Хишигсүх (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Б.Итгэлт (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Б.Батмөнх (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Жеймс Пассин (ТУЗ-ийн гишүүн)-Хараат М.Батсүрэн (ТУЗ-ийн гишүүн)-Хараат бус О.Цэндсүрэн (ТУЗ-ийн гишүүн)-Хараат бус Ж.Батсүүр (ТУЗ-ийн нарийн бичиг)
Гүйцэтгэх Удирдлага	Б.Батбаатар (Гүйцэтгэх Захирал) Ө.Хишигсүх (Ерөнхий Захирал)
Нэгтгэгдсэн охин компани	“Нагай” ХХК 100%
Байнгын хаяг	“Шарын Гол” ХК “Шарын гол” ХК-ийн байр, 3-р баг, Санжит Шарын гол сум, Дархан-Уул аймаг, Монгол улс
Аудитор	“БДО Аудит” ХХК Юнион Бюлдинг, 15-р давхар, 1502 тоот Юнескогийн гудамж, Нарын зам-62 Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Улаанбаатар хот, Монгол Улс

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“Шарын Гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Санал дүгнэлт

Бид “Шарын гол” ХК болон түүний охин компаниудын (нийтэд нь ‘Групп’ гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2018 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийг томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь группийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (‘АОУС’)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (‘НБЁЗОУСЗ’)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НБЁЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Өөдрөг төсөөлөлтэй холбоотой материаллаг тодорхой бус байдал

Групп нь Тэмдэглэл 2-д дурдсанчлан өөдрөг (тасралтгүй ажиллагааны) төсөөлөлд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн. Удирдлага үйл ажиллагааг зогсоох бодитой төлөвлөгөөтэй, эсвэл үүнээс өөр аргагүй бодитой нөхцөл үүсэхээс бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн энэхүү суурийг ашигладаг. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад бид удирдлагын тасралтгүй ажиллагааны суурь ашигласан нь буруу биш гэж дүгнэсэн.

Санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 2-д дурьдсан 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группын эргэлтийн өр төлбөр нь эргэлтийн хөрөнгөөс 14 тэрбум төгрөгөөр давсан асуудлыг удирдлагын анхааралд хүргэж байна. Эдгээр үйл явдал, нөхцөл байдал болон Тэмдэглэл 2-д тусгагдсан бусад асуудлууд нь компанийн тасралтгүй үйл ажиллагаа үргэлжлэх эсэхэд эргэлзээ төрүүлж болзошгүй материаллаг тодорхой бус байдлыг үүсгэж байна. Энэ асуудлаар бид дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Асуудлыг онцлох нь

Тэмдэглэл 38 Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага хэсгийг нэгтгэсэн санхүүгийн тайлан хэрэглэгчид анхааралтай авч үзвэл зохино. Бид Группийн Хүлээж болзошгүй үүрэг хариуцлага холбоотой асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

Аудитын гол асуудлууд

1. Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 17,689,834 мянган төгрөгийн дансны үнэ бүхий уурхайн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт нь Тэмдэглэл 5(h)-д тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Групп нь бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргыг ашигладаг бөгөөд уурхайн нийт нөөцийг тодорхойлох болон уурхайн хөрөнгийг үйлдвэрлэлийн нэгжид хуваарилахтай холбоотой шийдлүүд гаргадаг.

2. Нөхөн сэргээлтийн сангийн нөөц

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нөхөн сэргээлтийн сангийн үлдэгдэл нь 10,513,072 мян.төгрөг байсан. Группийн нөхөн сэргээлтийн нөөц нь Тэмдэглэл 30(a)-д тусгагдсан. Түүнчлэн 4(h)-д тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Нөөцийг тодорхойлоход мөнгөний урсгал, зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай ажлыг гүйцэтгэхэд удирдлагын үнэлэмж хэрэгтэй байдаг.

3. Ажилчдын тэтгэвэрийн сангийн нөөц

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 2,277,834 мянган төгрөгийн тэтгэмжийн сангийн нөөц үлдэгдэлтэй байсан. Группийн Ажилчдын тэтгэвэрийн нөөц нь Тэмдэглэл 30(b)-д тусгагдсан. Нөөцийг тодорхойлоход хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй мөнгөн урсгалын зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай нарийн төвөгтэй ажлыг гүйцэтгэхэд удирдлагын шийдэл шаардагдах учраас бид энэ асуудлыг аудитын гол асуудалд оруулсан.

Аудитын хариу

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх хүдрийн агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан. ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн үр чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталжуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн. Мөн бид цэвэр боломжит үнэ цэнийн тесттэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнэ болон одоогийн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

Аудитын хариу

Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн үр чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон төсөөллийг үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшинг үнэлсэн.

Аудитын хариу

Бид аудитын явцад хөндлөнгийн актуарчийг аудиторын шинжээчээр ажиллуулж, тэтгэмжийн сангийн тооцоололтой холбоотойгоор удирдлагын ашигласан мэргэжлийн үр чадвар, тооцооллын бодитой байдлыг үнэлсэн. Үүнд хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хуваарилалт, зохистой дискаунтын түвшин зэргийг үнэлсэн. Энэхүү аудиторын шинжээчийн ажилд суурилан бид удирдлагын тооцооллыг үл үндэслэлтэй гэж үнэлсэн.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Нэгтгэсэн санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага(үргэлжлэл)

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын түршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 95.1-р зүйлд заасан дагуу зөвхөн "Шарын Гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Д.АЛТАНСҮХ
БДО Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО гудамж, Нарны зам-62
ЮНИОН Бюлдинг В блок, 1502 тоот өрөө

Огноо: 2019 .04. 04

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тэм	Групп		Компани	
		2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Борлуулалтын орлого	8	48,687,562	48,875,033	48,687,562	48,847,101
Борлуулалтын өртөг	9	(40,674,974)	(39,184,502)	(41,564,233)	(38,954,315)
Нийт ашиг		8,012,588	9,690,531	7,123,329	9,892,786
Ерөнхий ба удирдлагын зардал	10	(3,223,697)	(2,965,659)	(2,800,812)	(2,626,409)
Борлуулалт, маркетингийн зардал	11	(252,587)	(404,138)	(252,587)	(404,138)
Үйл ажиллагааны ашиг		4,536,304	6,320,734	4,069,930	6,862,238
Санхүүгийн орлого	12	336,383	2,463,497	315,718	2,454,759
Санхүүгийн зардал	13	(5,278,077)	(4,408,628)	(4,899,927)	(4,178,902)
Бусад орлого	14	208,586	130,608	208,461	130,608
Бусад зардал	15	(4,183,824)	(1,262,158)	(4,177,637)	(1,239,526)
Бусад олз/(гарз)	16	4,298,447	(11,956)	40,686	(11,956)
Татварын өмнөх ашиг(алдагдал)		(82,181)	3,232,097	(4,442,769)	4,017,221
Орлогын албан татварын (зардал)/өгөөж	17	121,143	(886,735)	190,148	(886,432)
Татварын дараах цэвэр ашиг/(алдагдал)		38,962	2,345,362	(4,252,621)	3,130,789
Татварын жилийн ашиг/(алдагдал)					
Хувьцаа эзэмшигчдэд ногдох		(101,325)	2,415,791	(4,252,620)	3,130,789
Хяналтын бус багц эзэмшигчид ногдох		140,287	(70,429)	-	-
		38,962	2,345,362	(4,252,620)	3,130,789
Бусад дэлгэрэнгүй орлогын тайлан:					
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	31,012	-	31,012
Дахин үнэлгээний нөөцийн бууралт		413,769	(17,476)	413,769	(17,476)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй		452,731	2,358,898	(3,838,851)	3,144,325
Хувьцаа эзэмшигчид		312,444	2,429,327	(3,838,852)	3,144,325
Хяналтын бус багц эзэмшигчид		140,287	(70,429)	-	-
		452,731	2,358,898	(3,838,852)	3,144,325
Нэгж энгийн хувьцаанд ногдох үндсэн болон хорогдуулсан ашиг(алдагдал) төгрөг	18	(9.96)	237.54	(418.14)	307.84

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тэм	Групп		Компани	
		2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төгс
ХӨРӨНГӨ					
Эргэлтийн бус хөрөнгө					
Өмч, Барилга, Тоног төхөөрөмж	19	41,391,465	38,202,509	40,693,312	35,763,345
Биет бус хөрөнгө	20	89,185	23,676	88,879	22,214
Уурхайн хөрөнгө	21	17,689,834	19,210,960	17,689,834	19,210,960
Урт хугацаат хөрөнгө оруулалт	7, 22	453,644	-	878,644	2,209,830
Хойшлогдсон татварын хөрөнгө	17	537,521	73,062	537,521	62,957
Гүүдвилл	7	424,990	424,990	-	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		60,586,639	57,935,197	59,888,190	57,269,306
Эргэлтийн хөрөнгө					
Бараа материал	23	2,698,644	2,454,417	2,698,644	2,424,576
Урьдчилж төлсөн зардал ба бусад эргэлтийн хөрөнгө	24	386,665	1,133,409	386,665	1,023,542
Худалдааны ба бусад авлага	25	2,150,356	6,011,414	1,899,848	8,198,376
Мөнгөн хөрөнгө	26	3,164,364	900,181	3,161,849	849,614
Нийт эргэлтийн хөрөнгө		8,400,029	10,499,421	8,147,006	12,496,108
НИЙТ ХӨРӨНГӨ		68,986,668	68,434,618	68,035,196	69,765,414
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР					
Өмч					
Хувьцаат капитал	27	1,017,024	1,017,024	1,017,024	1,017,024
Нэмж төлөгдсөн капитал	27	23,145,158	23,145,158	23,145,158	23,145,158
Дахин үнэлгээний нэмэгдэл	27	9,632,468	10,046,237	9,632,468	10,046,237
Хуримтлагдсан алдагдал		(12,686,876)	(12,999,320)	(13,169,405)	(9,330,553)
Нийт өмч		21,107,774	21,209,099	20,625,245	24,877,866
Хяналтын бус багц эзэмшигчид		-	(140,287)	-	-
НИЙТ ӨМЧ		21,107,774	21,068,812	20,625,245	24,877,866
Өр төлбөр					
Эргэлтийн бус өр төлбөр					
Урт хугацаат зээл	28	8,398,477	12,135,650	8,398,477	12,135,650
Урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	29	1,808,277	-	1,808,277	-
Урт хугацаат зээлийн хүүгийн өглөг	28	1,882,795	-	1,882,795	-
Сангууд	30	12,790,783	12,564,883	12,790,783	12,564,883
Нийт урт хугацаат өр		24,880,332	24,700,533	24,880,332	24,700,533

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

	Тэм	Групп		Компани	
		2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Эргэлтийн өр төлбөр					
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг	28	-	338,359	-	-
Богино хугацаат зээл	28	5,838,593	4,243,461	5,838,593	3,151,628
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	29	3,890,306	3,506,862	3,890,306	3,506,862
Хүүгийн өглөг	28, 29	817,431	5,542,227	817,431	4,892,030
Хураамжийн өглөг	28	120,742	146,616	120,742	146,616
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн өглөг	28	-	33,987	-	-
Худалдааны ба бусад өглөг	31	9,143,592	8,152,051	8,734,774	7,789,599
Гэрээний өр төлбөр	32	2,356,410	20,560	2,356,410	20,560
Татварын өглөг	33	831,488	681,151	771,363	679,720
Нийт эргэлтийн өр төлбөр		22,998,562	22,665,273	22,529,619	20,187,015
Нийт өр төлбөр		47,878,894	47,365,806	47,409,951	44,887,547
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		68,986,668	68,434,618	68,035,196	69,765,414

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тэм	Групп		Компани	
		2018 он төгрөг	2017 он төгрөг	2018 он мян.төг	2017 он мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Татварын өмнөх ашиг/(алдагдал)		(82,182)	3,232,097	(4,442,769)	4,017,222
Тохируулга:					
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол болон шавхагдал	19,20, 21	7,690,567	6,998,182	7,518,673	6,896,176
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз	19	284,097	11,956	284,097	11,956
Бараа материалын үнэ цэнийн бууралт гарз	16	(953,708)	-	(953,708)	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулалтын (олз)/гарз	16	322,800	-	322,800	-
Охин компанийн хувьцаа борлуулсны гарз	16	115,956	-	115,956	-
Өмч, барилга, тоног төхөөрөмж үнэ цэнийн бууралтын гарз	16	175,906	-	175,906	-
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт	16	14,263	-	14,263	-
Хөрс хуулалтын хөрөнгийн хэрэгжилт	21	-	2,704,117	-	2,704,117
Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл	13	14,005	755,162	14,005	755,162
Ажилчдын тэтгэврийн сангийн зардал	9, 10, 11	921,234	186,363	921,234	186,363
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн өр	12, 13	-	(1,185,867)	-	(1,185,867)
Найдваргүй авлагын зардал	15	2,721,454	49,452	2,721,454	49,452
Хүү болон зээлийн хураамжийн зардал	13	3,123,460	2,750,398	2,916,423	2,550,284
Хүүгийн орлого	12	(51,905)	(18,384)	(43,237)	(18,384)
Валютын ханшийн бодит бус гарз(олз)	12, 13	1,962,912	(658,180)	1,819,084	(686,267)
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг		16,258,859	14,825,295	11,384,181	15,280,214
Ажлын капиталын өөрчлөлт:					
Бараа материалын (өсөлт)/бууралт	23	(4,546,093)	(117,384)	(288,331)	(264,496)
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт	24, 25	1,756,548	(73,742)	4,252,577	(399,995)
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)	31	3,179,802	82,292	581,984	62,465
Гэрээний хөрөнгийн (өсөлт)/бууралт	32	2,335,851	-	2,335,851	-
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн үрсгал		18,984,967	14,716,461	18,266,262	14,678,188
Төлсөн орлогын татвар	33	(500,000)	(100,000)	(500,000)	(100,000)
Хүүгийн төлөлт	28	(4,476,907)	(1,500,686)	(4,476,907)	(1,500,686)
Хүлээн авсан хүү	13	51,905	18,384	43,237	18,384
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		14,059,965	13,134,159	13,332,592	13,095,886

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (үргэлжлэл)

		Групп		Компани	
	Тэм	2018 он төгрөг	2017 он төгрөг	2018 он мян.төг	2017 он мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	22	832,480	-	832,480	-
Дуусаагүй барилгын нэмэгдсэн өртөг	19	(13,636)	(1,286)	(13,636)	(1,286)
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн худалдан авалт	19	(6,879,863)	(4,106,738)	(6,108,038)	(4,116,161)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	20	(89,617)	(660)	(89,617)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(6,150,636)	(4,108,684)	(5,378,811)	(4,117,447)
САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ					
Хүлээн авсан зээл	28	8,253,869	-	8,253,869	-
Эргэн төлсөн зээл	28	(10,499,172)	(6,067,725)	(10,499,172)	(6,067,725)
Санхүүгийн түрээсийн буцаалт орж ирсэн мөнгө		622,686	-	622,686	-
Санхүүгийн түрээсийн төлбөр	29	(3,925,753)	(2,839,571)	(3,925,753)	(2,839,571)
Санхүүжилтийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(5,548,370)	(8,907,296)	(5,548,370)	(8,907,296)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр(бууралт)/өсөлт		2,264,650	112,673	2,312,235	65,643
Гадаад валютын ханшийн зөрүү		(96,309)	(5,507)	(93,176)	(5,501)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26	900,181	787,508	849,614	397,686
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26	3,164,831	900,181	3,161,849	783,972
Хөрөнгө оруулалт ба санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээний нэмэлт тодруулга					
Охин компанийг борлуулсны гарз(олз)		(4,257,761)	-	-	-
Санхүүгийн түрээсээр авсан Өмч, барилга, тоног төхөөрөмж		(7,583,433)	2,844,953	(7,583,433)	2,844,953
Санхүүгийн түрээсийн тоног төхөөрөмжийн худалдан авалтын буцаалт		(1,995,480)	-	(1,995,480)	-
Хөрс хуулалтын хөрөнгийн буцаалт		-	2,704,117	-	2,704,117
Уурхайн хөрөнгөнд капиталжуулсан нөхөн сэргээлтийн сангийн өөрчлөлт	30	994,856	(2,504,872)	994,856	(2,504,872)
Дахин үнэлгээний нэмэгдэл	19, 27	-	31,012	-	31,012
Дахин үнэлгээний хэрэгжилт	19, 27	(413,769)	(17,476)	(413,769)	(17,476)

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Группийн түвшинд	Тэм	Хувьцаат капитал мян.төг	Хувьцааны урамшуулал мян.төг	Дахин үнэлгээний нэмэгдэл мян.төг	Хуримтлагдсан ашиг/(алдагдал) мян.төг	Нийт мян.төг	Хяналтын бус багц мян.төг	Нийт мян.төг
2017 оны 01 сарын 01-ний өдрөөрх үлдэгдэл		1,017,024	23,145,158	10,032,702	(15,432,588)	18,762,296	(69,859)	18,692,437
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		-	-	-	2,415,791	2,415,791	(70,429)	2,345,362
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	13,535	17,477	31,012	-	31,013
2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл		1,017,024	23,145,158	10,046,237	(12,999,320)	21,209,099	(140,288)	21,068,811
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		-	-	-	(101,325)	(101,325)	140,287	38,962
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	(413,769)	413,769	-	-	-
2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл		1,017,024	23,145,158	9,632,468	(12,686,876)	21,107,774	-	21,107,774

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН (үргэлжлэл)

Компанийн түвшинд	Тэм	Хувьцаат капитал мян.төг	Хувьцааны урамшуулал мян.төг	Дахин үнэлгээний нэмэгдэл мян.төг	Хуримтлагдсан ашиг/(алдагдал) мян.төг	Нийт мян.төг
2017 оны 01 сарын 01-ний өдрөөрх үлдэгдэл		1,017,024	23,145,158	10,032,701	(12,478,818)	21,716,065
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		-	-	-	3,130,789	3,130,789
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	13,536	17,476	31,012
2017 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл		1,017,024	23,145,158	10,046,237	(9,330,554)	24,877,865
Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)		-	-	-	(4,252,620)	(4,252,620)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдлаар	27	-	-	(413,769)	413,769	-
2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх үлдэгдэл		1,017,024	23,145,158	9,632,468	(13,169,405)	20,625,245

16-77-р хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

“ШАРЫН ГОЛ” ХК болон охин компаниуд

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“Шарын гол” ХК (“Компани”) нь Монгол улсад нүүрсний хайгуул, хөгжүүлэлт болон үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

Компани нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй, Монгол Улсад байгуулагдсан, түс улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хувьцаат компани юм. Компанийн албан хаяг Монгол Улс, Дархан-Уул аймаг, Шарын гол сүм, Санжит баг бөгөөд өөрийн байранд байрладаг.

“Шарын Гол” ХК нь 2006 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд шинэчлэн бүртгүүлж, 2050374 регистр бүхий 1910010009 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

10-н том хувьцаа эзэмшигчид	Хувь	Тоо
1. Эс Эйч Жи Холдингс 3 С.а.р.л.	22.80%	2,318,451
2. Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л.	19.95%	2,028,906
3. Нихан Холдингс С.а.р.л.	15.72%	1,598,889
4. Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк	11.39%	1,158,520
5. Эс Эйч Жи Холдингс С.а.р.л.	11.24%	1,142,674
6. Могул Ресурсес Инк.	9.83%	1,000,000
Бусад	9.07%	922,802
Нийт	100%	10,170,242

2016 оны 09 дүгээр сарын 13-нд компани “Нагай” ХХК (“Охин компани”)-ийг 425 сая төгрөгөөр худалдан авсан. “Нагай” ХХК нь 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд шинэчлэн бүртгүүлж, 6039146 регистр бүхий 9011590138 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

2013 оны 9 дүгээр сарын 23-нд компани “Нако Түлш” ХК (“Охин компани”)-ийн 92.93% буюу 11,723,989 хувьцааг 2.5 тэрбум төгрөгөөр худалдан авсан. “Нако Түлш” ХК нь 2007 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Монгол улсын Улсын бүртгэлийн албанд шинэчлэн бүртгүүлж, 4489969 регистр бүхий 1910001019 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. 2018 оны 12-р сарын 19-ний өдөр эзэмшиж буй хувьцааныхаа 7,588,671 ширхгийг борлуулж нийт хувьцааны 32.779%-ийг эзэмшдэг болж уг өдрөөр охин компани дах хяналтаа алдсан.

Групп нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нийт 507 ажиллагсадтай байсан.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

2. ӨӨДРӨГ ТӨСӨӨЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛЛАГ ТОДОРХОЙ БУС БАЙДАЛ

Групп Тэмдэглэл 2-д дурдсанчлан тасралтгүй ажиллагааны төсөөлөлд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

Групп нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд групп нь 12,686,876 мянган төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилд группийн эргэлтийн өр төлбөр нь эргэлтийн хөрөнгөөс 14,598,533(2017: 12,165,852)мянган төгрөгөөр давсан байна. Групп нь тайлант жилд 14,059,965 (2017: 13,134,159) мянган төгрөгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгалтай ажилласан боловч тайлант жилд 6,150,636 (2017: 4,108,684)мянган төгрөгийн капитал зарцуулалт хийж, мөн санхүүгийн өр төлбөрийн эргэн төлөлтөд 5,548,370(2017:8,907,296) мянган төгрөг, эдгээрийн нийлбэрээр санхүүжилтийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа 11,699,006 (2017:13,015,980) мянган төгрөг зарцуулж, тайлант жилд 2,264,650(2017:112,673) мянган төгрөгийн эерэг мөнгөн урсгалтай ажилласан байна.

Гэсэн хэдий ч Санхүүгийн тайлангийн тэмдэглэл 6(с)-д харуулсанчлан, ирэх 12 сарын хугацаанд 10,667,071 мянган төгрөгийн санхүүгийн өр төлбөр төлөх хүлээлттэй байгаа нь тайлант жил болон өмнөх тайлант жилийн санхүүгийн өр төлөлтийн түүхэн дунджаас давсан төлбөрийн чадварын хүндрэл үүсгэж болзошгүйг илтгэж байна.

Компанийн удирдлагаас бэлтгэсэн 2019 оны бизнес төлөвлөгөө дэх нийт цэвэр мөнгөн урсгал нь 3,579,065 мянган төгрөг, ХТЭӨА нь 11,630,523 мянган төгрөг байна.

Шарын Гол ХК нь Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц ТӨХК, Дарханы Дулааны Цахилгаан Станц ТӨХК зэрэг томоохон төрийн өмчит компаниудад Эрчим Хүчний Зохицуулах хорооны тогтоолоор баталсан зохицуулалттай үнээр нүүрсээ борлуулдаг. Мөн групп нь Дархан-Уул аймгийн Шарын Гол сумын нутагт орших Буянтын хөндийн адаг хэсгийн алтны шороон ордын MV-001498 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд алт олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд алт олборлолтын орлогоор ирээдүйд ихээхэн хэмжээний мөнгөн урсгалыг бий болгохоор төлөвлөж байна.

2019 онд батлагдсан ТЭЗҮ-ээр цаашид олборлох боломжтой алтны цэвэр нөөцийн хэмжээ 121 кг байна. Мөн 2013 онд батлагдсан ТЭЗҮ-ээр нүүрсний цаашид ашиглах нөөцийн хэмжээ нь ойролцоогоор 26 сая тонн гэж тогтоосон байна.

Иймд группийн удирдлагууд цаашид олборлох нүүрсний нийлүүлэлтийн найдвартай худалдан авагчид, олборлох боломжтой алтны нөөцийн үл үндэслэлтэй тооцоолол зэрэгт суурилан группийн тасралтгүй үйл ажиллагаанд ямар нэгэн тодорхой бус байдал үүсэхгүй гэдэгт итгэлтэй байгаа болно.

3. НЭГТГЭСЭН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь СТОУС 10 *Нэгтгэсэн санхүүгийн тайлан*-ийн дагуу нэгтгэгч компани болох “Шарын Гол” ХК болон түүний охин компани болох “Нако Түлш” ХК, “Нагай” ХХК-ийн бие даасан санхүүгийн тайлангуудыг нэгтгэсэн дүнг илэрхийлж байгаа бөгөөд нэгтгэлд хамрагдаж буй санхүүгийн тайлангууд нь ижил хугацаагаар тасалбар болж, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн нэг ижил бодлого баримтлан бэлтгэгдсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэгдсэн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын тухай мэдээллийг 34 дүгээр тэмдэглэлд оруулсан. Холбогдох хэсэгт тусгайлан зааснаас бусад тохиолдолд тэмдэглэл 34-д заасан бодлогуудыг хэрэглэсээр ирсэн.

Группийн үйл ажиллагааны болон тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг болно. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнагдсан.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

3. НЭГТГЭСЭН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

Компани нь санхүүжигч талд хяналттай бол тухайн санхүүжигч талыг охин компани гэж ангилна. Дараах хяналтын гурван шалгуурыг бүгдийг нь хангасан тохиолдолд компанийг санхүүжигч талд хяналттай гэж үзнэ. Үүнд:

- Санхүүжигч талыг зохицуулах эрх мэдэлтэй;
- Санхүүжигч талын үйл ажиллагаанаас төрөл бүрийн өгөөж хүртдэг; бөгөөд
- Өөрт буй эрх мэдлээ тухайн өгөөжид нөлөөлөхүйц байдлаар ашиглах чадвартай.

Эдгээр хяналтын шалгуур өөрчлөгдсөн байж болзошгүй гэж үзэхэд хүргэсэн баримт, нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналтыг дахин үнэлнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Компанийн болон түүний охин компаниудын (“Групп”) үр дүнг нэг аж ахуйн нэгж мэтээр тайлагнадаг. Иймд толгой компани болон охин компанийн хооронд хийгдсэн ажил гүйлгээнүүд болон үлдэгдлийг бүрэн цэвэрлэдэг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ, толгой болон охин компаниудын санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого болон зардлын ижил төстэй зүйл тус бүрийн дүнг мөр мөрөөр нь нэмж нэгтгэсэн.

Дараах зүйлсийг нэгтгэлээс цэвэрлэж тайлагнасан. Үүнд:

- a) Бүлэг доторх компаниудын хоорондын
 - Хөрөнгө, өр төлбөрийн данснуудын үлдэгдэл;
 - Орлого болон зардлын дүн;
- b) Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнэ болон өмчийн дүн.

4. ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

(а) 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

2018 оны 12 сарын 31-нээр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланд мөрдөгдөх, Компанид нөлөө үзүүлэх дараах шинэ стандартууд нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулсан:

- СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр; болон
- СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Эдгээр хоёр стандартын нөлөөний дэлгэрэнгүйг Тэмдэглэл 36, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө-д оруулсан. Дараагийн санхүүгийн жилд анх удаа мөрдөгдөж эхлэх НББОУСЗ-өөс гаргасан бусад шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт болон тайлбарууд нь Компанид нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Мөн түүнчлэн эдгээр нь Компанийн үйл ажиллагаа эсвэл Компанийн одоогийн нягтлан бодох бүртгэлийн бодлоготой нийцсэн нягтлан бодох бүртгэлийн хэрэгцээ шаардлагатай хамааралгүй болно.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

4. ШИНЭ СТАНДАРТ, ТАЙЛБАР БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД (үргэлжлэл)

(б) Хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа шинэ стандартууд, түүний тайлбарууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компани хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхээр шийдээгүй буюу ирээдүйн нягтлан бодох бүртгэлийн үеүдэд хэрэгжих НББОУСЗ-өөс батлан гаргасан хэд хэдэн стандартууд болон тайлбарууд байна. Тэдгээрээс гол нөлөө бүхий стандартууд нь:

- СТОУС 16 Түрээс

СТОУТХ 23 Орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд	Хэрэгжих огноо
СТОУС 16 2016 оны 01 дугаар сард гаргасан	СТОУС 16 нь НББОУС 17, Түрээс, СТСБХ 4, түрээс агуулсан хэлцэл эсэхийг тодорхойлох, ТБХ 15, Үйл ажиллагааны түрээс – Урамшуулал, ТБХ 27, Түрээсийн эрх зүйн хэлбэртэй холбоотой ажил гүйлгээний мөн чанарыг үнэлэх зэрэг стандарт, тайлбаруудыг орлоно. СТОУС 16-ын гол томоохон өөрчлөлт нь үйл ажиллагааны болон санхүүгийн түрээсийн хоорондын ялгааг арилгах мөн санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн "ашиглах эрхийг" болон түрээсийн гэрээний өр төлбөрийг тусгах цор ганц загварыг тодорхойлсон.	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд заавал мөрдөнө. СТОУС 15 нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.
СТОУТХ 23 2017 оны 06 дугаар сард гаргасан	СТОУТХ 23 нь орлогын татвартай холбоотой тодорхой бус байдал байгаа үед тайлант жилийн болон хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэрхэн хэмжиж хүлээн зөвшөөрөхийг илүү тодорхой болгож өгсөн.	2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд мөрдөнө

Бусад

Компани Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан боловч хараахан мөрдөгдөж эхлээгүй байгаа дараах стандартууд нь компанид материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

- СТОУС 9 Сөрөг нөхөн төлбөр бүхий урьдчилгаа төлбөрийн онцлог дах нэмэлт өөрчлөлт (2019 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)
- НББОУС 28: Хараат болон хамтарсан үйлдвэр дэх урт хугацаат хувь оролцоо дах нэмэлт өөрчлөлт (2019 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)
- СТОУС-ын жилийн сайжруулалтууд – 2015-2017 оны цикл (СТОУС 3 Бизнесийн нэгдэл, СТОУС 11 Хамтын хэлэлцээр, НББОУС 12 Орлогын албан татвар болон НББОУС 23 Зээлийн өртөг) (2019 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)
- СТОУС 17 Даатгалын гэрээ (2021 оны 01 сарын 01-нээс мөрдөнө)

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

Групп нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

а) Үнэ цэнийн бууралт

Хөрөнгө эсвэл хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээсээ давбал үнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Эргэн төлөгдөх дүнг тогтоохдоо удирдлага нь группийн хэмжээний хөрөнгө түс бүрийн эсвэл мөнгө бий болгогч нэгжийн ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоолж, эдгээр мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд тохирох хүүг сонгож ашигладаг. Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгалыг хэмжихдээ удирдлага нь группийн удирдлагын шийдвэрийг ашигладаг. Группийн удирдлагын ашигласан төсөөлөл нь ирээдүйд болох тодорхой нөхцөл байдал болон үйл явдлуудтай холбоотой байдаг. Бодит үр дүн нь өөр байж болох ба энэ нь дараагийн санхүүгийн жилд багтаж Группийн хөрөнгүүдэд хийгдэх томоохон залруулгуудын шалтгаан байж болно.

Группийн удирдлага нь тохирох хөнгөлөлтийн түвшнийг тодорхойлохдоо зах зээлийн эрсдэл болон хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлийн тохируулгыг хийдэг. Ихэнх тохиолдолд группийн удирдлага нь группийн хэмжээний үнэ цэнийн бууралтын шалгалтыг хийхдээ мэргэжлийн хараат бүс үнэлгээчдийн тооцооллыг ашигладаг.

б) Бодит үнэ цэнийн хэмжилт

Групп үүсмэл санхүүгийн өр төлбөр болон бодит үнэ цэнээр хэмжигдэх үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хэмждэг.

Бодит үнэ цэнийг нь хэмждэг бүх хөрөнгө, өр төлбөрүүдийг санхүүгийн тайланд бодит үнэ цэнийн түвшнээр ангилсан ба доор дурдсанчлан, бүхлээрээ бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

Түвшин 1: ижил хөрөнгө, өр төлбөрийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ;

Түвшин 2: шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөөтэй орцуудыг ашигладаг техникүүд

Түвшин 3: ажиглах боломжтой зах зээлийн тоо баримтад үндэслээгүй бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөөтэй орцуудыг ашигладаг техникүүд.

Үүсмэл санхүүгийн өр төлбөр болон үндсэн хөрөнгийн аль алиныг 3 түвшний хэмжилтэд авч үзсэн.

Бодит үнэ цэнэ нь хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд гарч буй гүйлгээнд хөрөнгийг борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй дүн юм. Бодит үнэ цэнийн хэмжилт нь хөрөнгийг борлуулж буй эсвэл өр төлбөрийг шилжүүлж буй гүйлгээний дараах таамаглалд үндэслэдэг:

- Тухайн хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд болж буй, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед, тухайн хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд болж буй
- Үндсэн болон хамгийн давуу зах зээлд Групп нь оролцох боломжтой байх ёстой.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ (үргэлжлэл)

(b) Бодит үнэ цэнийн хэмжилт(үргэлжлэл)

Санхүүгийн үүсмэл өр төлбөр

Үүсмэл өр төлбөрийг давамгайлах эрсдэлгүй хүү, Монгол улс дах хамгийн сайн харьцуулалт болж чадах компаниудын хувьцааны үнийн тогтворгүй байдал, гадаад валютын ханшийн тогтворгүй байдал, тооцсон үнэ болон дуусгавар хугацаа хүртэлх хугацаа гэх мэтийг харгалзан үзсэн стандарт опцион үнэ тогтоох загварыг ашиглан үнэлсэн. Энэ нь 3-р түвшний хэмжилт болно.

Үндсэн хөрөнгө

Групп барилга, машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бодит үнэ цэнийг элэгдүүлсэн орлуулах өртөгт үндэслэн тодорхойлсон бөгөөд харин тавилга, тоног төхөөрөмж, компьютерын бодит үнэ цэнийг зах зээлийн үнэд үндэслэн тодорхойлсон.

Санхүүгийн тайланд байнгын сууриар хүлээн зөвшөөрдөг хөрөнгө, өр төлбөрүүдийн хувьд, Групп нь тайлант хугацаа бүрийн эцэст түвшнүүдийн хооронд шилжилт гарсан эсэхийг шинжлэхээр ангиллыг (бүхлээрээ бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод суурилсан) дахин үнэлж үздэг.

Түвшнүүдийн хоорондох шилжилт

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдийн хувьд бодит үнэ цэнийн 1-ээс 3 түвшний хооронд ямар нэг шилжилт байхгүй.

Бодит үнэ цэнээрээ бүртгэгдээгүй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн хэрэглүүрт бодит үнэ цэнээрээ хараахан бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлоход ашигласан аргачлал болон төсөөллийг доор дурдав:

Бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо бодит үнэ цэнэтэй санхүүгийн хэрэглүүр

Урт хугацааны хүүтэй зээл болон санхүүгийн түрээсийг эс тооцвол Группийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүд нь бүгд нэг жилээс бага дуусгавар хугацаатай, богино хугацаатай. Дээр дурдсан бодит үнэ цэнийн үнэлгээнд үндэслэсэн, эдгээр богино хугацаат санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх тооцоолсон бодит үнэ цэнэ нь санхүүгийн байдлын тайланд үзүүлсэн бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо байна.

Урт хугацаат, хүүтэй зээл болон санхүүгийн түрээсийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байна. Учир нь тэдгээр нь зах зээлийн харьцуулагдахуйц хэрэглүүрийн хүүтэй ойролцоо хүүтэй юм.

c) Элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Группийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон өмч, барилга, тоног төхөөрөмж гэх мэт элэгдэх хөрөнгийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно. Тэмдэглэл 34(k) болон 34(l)-д биет бус хөрөнгө, өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааны талаар дэлгэрэнгүй түсгасан.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

**2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)**

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ (үргэлжлэл)

d) Хөрс хуулалтын зардал

Группийн түвшинд	Тэм	Үр ашигт хүүний хувь	Үндсэн төлбөр		Хуримтлагдсан хүү, хураамж		Санхүүгийн үүсмэл хэрэглүүр		Нийт дүн	
			2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Урт хугацаат зээл										
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	7+1 сарын	-	12,135,650	-	2,642,671	-	-	-	14,778,321
Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК		ЛИБОР	6,642,257	-	1,452,297	-	-	-	8,094,554	-
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	(ii)		-	-	910,527	1,149,314	-	-	910,527	1,149,314
Ж.Бат	(iii)	10%	-	338,359	-	-	-	-	-	338,359
Хай Би ойл ХХК	(iv)	6%	1,756,220	-	430,498	-	-	-	2,186,718	-
Нийт зээл			8,398,477	12,474,009	2,793,322	3,791,985	-	-	11,191,799	16,265,994
Хасах нь: Урт хугацаат зээлийн богино хугацаат хэсэг										
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	7+1 сарын	-	-	-	2,642,671	-	-	-	2,642,671
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лимитед Лтд	(ii)	7+6 сарын	-	-	910,527	1,149,314	-	-	910,527	1,149,314
Ж.Бат	(iii)	10%	-	338,359	-	-	-	-	-	338,359
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг			-	338,359	910,527	3,791,985	-	-	910,527	4,130,344
Нийт урт хугацаат зээл			8,398,477	12,135,650	1,882,795	-	-	-	10,281,272	12,135,650

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

Группийн түвшинд	Тэм	Үр ашигт хүүний хувь	Үндсэн төлбөр		Хуримтлагдсан хүү, хураамж		Санхүүгийн үүсмэл хэрэглүүр		Нийт дүн	
			2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Богино хугацаат зээл										
Могоул Көүл Холдингс Пте Лтд	(iv)	10%	-	728,139	-	213,342	-	-	-	941,481
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л	(v)	15%	-	810,661	-	530,847	-	-	-	1,341,508
Хай Би Ойл ХК	(vi)	6%	-	1,612,828	-	298,579	-	-	-	1,911,407
ХОТ Холдингс С.а.р.л.	(vii)	15%	-	1,091,833	-	650,197	-	33,987	-	1,776,017
Ч.Оргилболд	(viii)	-	1,518,878	-	-	-	-	-	1,518,878	-
Монгол Улсын Хөгжлийн банк	(ix)	7.05%	4,319,715	-	15,853	-	-	-	4,335,568	-
Богино хугацаат зээл			5,838,593	4,243,461	15,853	1,692,965	-	33,987	5,854,446	5,970,413
Нэмэх нь: Урт хугацаат зээлийн богино хугацаат хэсэг										
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	7+1 сарын ЛИБОР	-	-	-	2,642,671	-	-	-	2,642,671
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	(ii)	7+6 сарын ЛИБОР	-	-	910,528	1,149,314	-	-	910,528	1,149,314
Ж.Бат	(iii)		-	338,359	-	-	-	-	-	338,359
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг			-	338,359	910,528	3,791,985	-	-	910,528	4,130,344
Нийт богино хугацаат зээл			5,838,593	3,905,102	(894,675)	(2,099,020)	-	33,987	4,943,918	1,840,069

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

Компанийн түвшинд	Тэм	Үр ашигт хүүний хувь	Үндсэн төлбөр		Хуримтлагдсан хүү, хураамж		Нийт дүн	
			2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Урт хугацаат зээл								
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	7+1 сарын	-	12,135,650	-	2,642,671	-	14,778,321
Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК		ЛИБОР	6,642,257	-	1,452,297	-	8,094,554	-
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	(ii)	7+6 сарын	-	-	910,527	1,149,314	910,527	1,149,314
Хай Би ойл ХХК	(iv)	6%	1,756,220	-	430,498	-	2,186,718	-
Нийт зээл			8,398,477	12,135,650	2,793,322	3,791,985	11,191,799	15,927,635
Хасах нь: Урт хугацаат зээлийн богино хугацаат хэсэг								
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	7+1 сарын	-	-	-	2,642,671	-	2,642,671
Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК	(i)	7+1 сарын	-	-	1,452,297	-	1,452,297	-
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	(ii)	7+6 сарын	-	-	910,527	1,149,314	910,527	1,149,314
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг			-	-	2,362,824	3,791,985	2,362,824	3,791,985
Нийт урт хугацаат зээл			8,398,477	12,135,650	430,498	-	8,828,975	12,135,650

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

Компанийн түвшинд		Үр ашигт хүүний хувь	Үндсэн төлбөр		Хуримтлагдсан хүү, хураамж		Нийт дүн	
			2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Богино хугацаат зээл								
Могоул Кеүл Холдингс Пте Лтд	(iv)	10%	-	728,139	-	213,342	-	941,481
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л	(v)	15%	-	810,661	-	530,847	-	1,341,508
Хай Би Ойл ХК	(vi)	6%	-	1,612,828	-	298,579	-	1,911,407
Ч.Оргилболд	(viii)	-	1,518,878	-	-	-	1,518,878	-
Монгол Улсын Хөгжлийн банк	(ix)	7.05%	4,319,715	-	15,853	-	4,335,568	-
Богино хугацаат зээл			5,838,593	3,151,628	15,853	1,042,768	5,854,446	4,194,396
Нэмэх нь: Урт хугацаат зээлийн богино хугацаат хэсэг								
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	7+1 сарын ЛИБОР	-	-	-	2,642,671	-	2,642,671
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лимитед Лтд	(ii)	7+6 сарын ЛИБОР	-	-	910,527	1,149,314	910,527	1,149,314
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг			-	-	910,527	3,791,985	910,527	3,791,985
Нийт богино хугацаат зээл			5,838,593	3,151,628	926,380	4,834,752	6,764,973	7,986,381

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

Тайлант хугацааны зээлийн хөдөлгөөн

Үндсэн төлбөр, Санхүүгийн үүсмэл хэрэглүүр	Тэм	2018 оны 01 сарын 01 мян.төг	Зээлийн эргэн төлөлт мян.төг	Валютын Ханш мян.төг	Шилжүүлсэн зээл мян.төг	Авсан зээл мян.төг	Бусад мян.төг	2018 оны 12 сарын 31 мян.төг
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	12,135,650	-	(171,800)	(11,963,850)	-	-	-
“Хэрлэн Онон Туул ББСБ” ХХК	(i)	-	(6,117,637)	796,044	11,963,850	-	-	6,642,257
Ж.Бат	(iii)	338,359	-	-	-	-	(338,359)	-
Могул Көүл Холдинг Пте Лтд	(iv)	728,139	(765,639)	37,500	-	-	-	-
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л	(v)	810,661	(852,411)	41,750	-	-	-	-
“Хай Би Ойл” ХК	(vi)	1,612,828	-	143,392	-	-	-	1,756,220
ХОТ Холдингс С.а.р.л.	(vii)	1,091,833	-	-	-	-	(1,091,833)	-
Ч.Оргилболд	(viii)	-	(911,153)	45,102	-	2,384,929	-	1,518,878
Монгол Улсын Хөгжлийн банк	(ix)	-	(1,852,332)	303,107	-	5,868,940	-	4,319,715
Зээлийн үндсэн төлбөрийн дүн		16,717,470	(10,499,172)	1,195,095	-	8,253,869	(1,430,192)	14,237,070
ХОТ Холдингс С.а.р.л.	(vii)	33,987	-	-	-	-	(33,987)	-
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн дүн		33,987	-	-	-	-	(33,987)	-
Үндсэн төлбөр, Санхүүгийн үүсмэл хэрэглүүр нийт дүн		16,751,457	(10,499,172)	1,195,095	-	8,253,869	(1,464,179)	14,237,070

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ (үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

Тайлант хугацааны зээлийн хүү, хураамжийн хөдөлгөөн

Хуримтлагдсан хүү, хураамж		2018 оны 01 сарын 01 мян.төг	Төлсөн Хүү мян.төг	Шилжүүлсэн мян.төг	Тайлагнасан татвар мян.төг	Валютын Ханш мян.төг	Хүүгийн зардал мян.төг	Бусад мян.төг	Суутган татвар мян.төг	2018 оны 12 сарын 31 мян.төг
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	2,606,938	-	(2,606,938)	-	-	-	-	-	(0)
Хэрлэн Онон Туул ББСБ ХХК	(i)	-	(3,344,990)	2,606,938	-	51,800	2,099,923	38,626	-	1,452,297
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд	(ii)	1,038,431	(138,550)	-	(185,800)	75,705	-	-	-	789,786
Могул Көүл Холдинг Пте Лтд	(iv)	213,342	-	-	-	-	-	(213,342)	-	-
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л	(v)	530,847	(365,344)	-	(331,161)	22,499	102,054	-	41,105	-
Хай Би Ойл ХК	(vi)	298,579	-	-	-	31,708	100,211	-	-	430,498
ХОТ Холдингс С.а.р.л.	(vii)	650,197	-	-	-	31,708	100,211	(782,116)	-	-
Монгол Улсын Хөгжлийн банк	(ix)	-	(115,236)	-	-	5	131,084	-	-	15,853
Санхүүгийн түрээс		203,893	(231,988)	(200,745)	-	-	240,632	-	-	11,792
Хуримтлагдсан хүүгийн дүн		5,542,227	(4,196,108)	(200,745)	(516,960)	213,425	2,774,115	(956,832)	41,105	2,700,226
Европын сэргээн босголт хөгжлийн банк	(i)	35,733	-	(35,733)	-	-	-	-	-	-
Хэрлэн Онон Туул ББСБ ХХК	(i)	-	(36,218)	35,733	-	485	-	-	-	-
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лимитед Лтд	(ii)	110,883	-	-	-	9,859	-	-	-	120,742
Хураамжийн дүн		146,616	(36,218)	-	-	10,344	-	-	-	120,742
Хуримтлагдсан хүү, хураамж		5,688,843	(4,232,326)	(200,745)	(516,960)	223,769	2,774,115	(956,832)	41,105	2,820,968

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

(i) Европын Сэргээн Босголт Хөгжлийн банкнаас авсан зээл

2014 оны 1 сарын 15-нд Компани нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн банктэй (ЕСБХБ) урт хугацаатай, барьцаагүй, 10.0 сая ам.долларын нийт дүнтэй хөрөнгө оруулалтын зээлийн гэрээг Хаан банкнаас авсан зээлийг төлөх болон нүүрс угаах үйлдвэрийн барилгын ажлыг санхүүжүүлэхээр байгуулсан. Зээлийг 2016 оны 1 сарын 15-наас эхлэн зургаа (6) хувааж (хагас жил тутамд 1.6 сая ам.доллар) төлөх нөхцөлтэй. Зээлийг гэрээ байгуулснаас хойш 2 жилийн дотор хэсэгчлэн авах боломжтой. Энэхүү зээл нь жилийн 7% дээр нэмэх нь 1 сарын ЛИБОР хүү нэмэгдэх ба мөн хугацаа хэтэрсэн боловч төлөгдөөгүй байгаа дүнгээс тооцсон 2% -ийн нэмэгдүүлсэн хүү нэмэгдэнэ. Компани нь зээлийн эхний хэсэг болох 5.0 сая ам.долларыг 2014 оны 5 сарын 16-нд авсан бөгөөд зээлийг Хаан банкнаас авсан зээлийг төлөхөд болон нүүрс угаах үйлдвэрийн барилгын ажлыг санхүүжүүлэхэд зарцуулсан.

Зээлийн гэрээний дагуу, компани нь гэрээнд заасан нөхцөлүүдийг биелүүлэх ёстой. Компани нь зээлийн гэрээгээр шаардсан дараах зүйлсийг зөрчсөн байна. Үүнд:

- Зээлдүүлэгчээс бичгээр зөвшөөрөл авалгүйгээс өөр зээлдэгчээс зээл авах;
- Зээлийг гэрээнд заасан хугацааны дагуу хугацаанд нь төлөх;
- Санхүүгийн харьцааны шалгуурыг ханган ажиллах;

2017 оны 12 сарын 22-ний өдөр ЕСБХБ болон Монголын Голд Минт ХХК нарын хооронд байгуулсан Даатгаварын гэрээний дагуу ЕСБХБ нь гэрээгээрх бүх үүрэг, эрхээ Монголын Голд Минт ХХК-д шилжүүлсэн. 2018 оны 07 сарын 25-ны өдөр Монгол Голд Минт ХХК болон Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК нарын хооронд Даатгаварын гэрээ байгуулан зээлийн бүх үүрэг, эрхээ Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК-д шилжүүлсэн. Групптэй байгуулсан зээлийн хугацаа 2018 оны 12 сарын 15-ний өдөр дуссан боловч боловч Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК нь зээлийг урт хугацаанд эргэн төлүүлэхээр тохиролцсон бөгөөд зээлийн гэрээг шинэчлэх үйл ажиллагаа хийгдэж байгаа.

2018 оны 12 сарын 31-ний байдлаар үндсэн зээлийн үлдэгдэл 6,642,257 мян.төг (2017: 12,135,650 мян.төг) түүний хүү болон бусад үүргийн төлөгдөөгүй үлдэгдэл 1,452,298 мян.төг (2017: 2,642,671 мян.төг) байна.

Тайлант хугацаанд Компани нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний 2.06 хэсэгт заасны дагуу компани нь гүйцэтгэлд суурилсан хүүг тооцож бүртгэсэн. Энэхүү гэрээний 2.06-д заасан гүйцэтгэлд суурилсан хүү гэдэг нь өмнөх жилийн хүү татвар элэгдэл хорогдлын өмнөх ашиг (ХТЭХӨА)-ийн суурь ХТЭХӨА-аас давсан хэсэгт 10%-аар ногдуулна. Энэхүү зээлийн эрхийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн банк нь Монгол Голд Минт ХХК руу шилжүүлэхдээ эх гэрээний бүх эрх, үүргийн хамт шилжүүлсэн бөгөөд Монгол Голд Минт ХХК нь мөн эх гэрээний эрх, үүргийн хамт Хэрлэн Онон Түүл ББСБ ХХК руу шилжүүлсэн. Компани гэрээний дээрх заалтын дагуу 2016 болон 2017 оны ХТЭХӨА-ийн суурь ХТЭХӨА-аас давсан хэсэгт ногдох нийт 1,214,971 мян.төгрөгийн хүүгийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

(ii) Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лимитед Лтд-н хөрвөх зээл

2014 оны 3 сарын 31-нд Компани нь Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лтд-тэй барьцаагүй, хөрвөх нөхцөлтэй, урт хугацаатай, 5.0 сая ам.долларын нийт дүнтэй хөрөнгө оруулалтын зээлийн гэрээг байгуулсан. Зээлийг гэрээний хугацаа дуусахаас 30 өдрийн өмнөх хугацаанд хэсэгчлэн авах боломжтой ба гэрээ байгуулагдсанаас 5 жилийн дараа төлөх нөхцөлтэй. Жилийн 7% -ийн хүүтэй ба 6 сарын ЛИБОР хүү нэмэгдэнэ. Компани нь зээлийн эхний хэсэг болох 2.5 сая ам.долларыг 2014 оны 5 сарын 5-нд авсан бөгөөд зээлийг нүүрс угаах үйлдвэрийн барилгын ажлыг санхүүжүүлэхэд зарцуулсан.

2017 онд зээлдүүлэгч нь зээлийг мөнгөөр төлүүлэхээр шийдвэрлэн нэхэмжилснээр үндсэн зээлийг 2017 онд бүрэн барагдуулсан. 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл 910,528 мян.төг (2017: 1,149,314 мян.төг) байна.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

(iii) Монгол улсын иргэн Ж.Батаас авсан зээл

“Нако Түлш” ХК-ийн гүйцэтгэх удирдлага асан Ж.Бат нь компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор зээл өгсөн. Тус зээлийг барагдуулуулахаар зээлдүүлэгч нь шүүхийн байгууллагад хандаж төлбөрийг барагдуул гэсэн шүүхийн шийдвэр гарсан. Тус төлбөрийг 2016 онд барагдуулж дуусах байсан ч барагдуулаагүй байна. 2018 оны 12 сарын 31-ний байдлаар зээлийн үндсэн төлөгдөөгүй үлдэгдэл нь 0 (2016: 338,359 мян.төг) мянган төгрөг байна.

(iv) Могоул Көүл Холдинг Пте Лтд-н хөрвөх зээл

2014 оны 3 сарын 31-нд Компани нь Могоул Көүл Холдинг Пте Лтд -тэй барьцаагүй, хөрвөх нөхцөлтэй, урт хугацаатай, 1.0 сая ам.долларын нийт дүнтэй хөрөнгө оруулалтын зээлийн гэрээг байгуулсан. Зээлийг гэрээний хугацаа дуусахаас 30 өдрийн өмнөх хугацаанд хэсэгчлэн авах боломжтой ба гэрээ байгуулагдсанаас 18 сарын дараа төлөх нөхцөлтэй, жилийн 10.0%-ийн хүүтэй бөгөөд хүү нь үндсэн төлбөрийн хамт хугацаа дуусах өдөр төлөгдөнө. Компани нь зээлийн эхний хэсэг болох 300 мянган ам.долларыг 2015 оны 8 сарын 21-нд авсан бөгөөд зээлийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан.

Зээлдүүлэгч нь үлдэгдэл зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн өглөгийн бүх эсвэл тодорхой хувийг зээлд заасны дагуу компанийн бүрэн төлөгдсөн энгийн хувьцаанд хөрвүүлэх боломжтой. Зээлийн өглөгийг хөрвүүлэлтийн өдрөөс хойш 6 сарын хугацааны жигнэсэн дундаж хувьцааны үнээр хөрвүүлнэ. Эргэлзээ үүсгэхээс зайлсхийх үүднээс хөрвүүлэх өдрийн Монгол Банкаас зарласан Америк Долларын ханшийг ашиглан хөрвүүлнэ гэж зээлийн гэрээгээр заасан.

Зээлийн гэрээний хугацаа 2017 оны 6 сарын 30-нд дууссан ба 2018 оны 3 сарын 28-ны өдөр зээлийн хугацааг 2018 оны 12 сарын 31 хүртэл сунгасан ба энэ нэмэлт өөрчлөлтөөр зээлийг хугацааны эцэст энгийн хувьцаа руу хөрвүүлэхгүй байхаар тохиролцсон. Зээлийн гэрээний дагуу компани нь тайлант онд зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн барагдуулсан (2017: үндсэн зээл 728,139 мян.төг, хүү болон бусад үүрэг 213,342 мян.төг).

(v) Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л-с авсан зээл

2014 оны 10 сарын 20-нд Компани нь Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л.-тэй барьцаагүй, богино хугацаатай, 334 мянган ам.долларын нийт дүнтэй, 3 сарын хугацаатай хөрөнгө оруулалтын зээлийн гэрээг байгуулсан. Жилийн 15% -ийн хүүтэй. Компани нь зээлийг 2014 оны 10 сарын 30-нд авсан бөгөөд зээлийг компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд санхүүжүүлэхэд зарцуулсан. Зээлийн гэрээг 2015 оны 11 сарын 13-ний нэмэлт өөрчлөлтөөр хугацааг 2016 оны 6 сарын 30 хүртэл, 2017 оны 01 сарын 24-ний нэмэлт өөрчлөлтөөр хугацааг 2017 оны 6 сарын 30 хүртэл сунгасан. 2018 оны 3 сарын 28- ний өдөр Гэрээний нэмэлт өөрчлөлт №4-өөр гэрээний хугацааг 2018 оны 12 сарын 31 хүртэл сунгасан. Хуримтлагдсан хүүг болон үндсэн зээлийг хугацааны эцэст төлөх үүрэгтэй.

2018 оны 4 сарын 19-ний өдөр зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт хийн зээлдэгчийн нэрийг Фаярбөрд Глобал Мастер Фанд болгон өөрчилсөн.

Компани нь тайлант онд үндсэн зээлийг түүний хуримтлагдсан хүүгийн хамт бүрэн барагдуулсан (2017: зээлийн үндсэн болон хүүгийн өглөгүүд нь харгалзан 810,661 болон 530,847 мян.төг тус байсан).

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

(vi) “Хай Би Ойл” ХК-с авсан зээл

2014 оны 6 сарын 30-нд Компани нь “Хай Би Ойл” ХК-тай барьцаагүй, богино хугацаатай, 500 мянган ам.долларын нийт дүнтэй, 3 сарын хугацаатай хөрөнгө оруулалтын зээлийн гэрээг байгуулсан. Жилийн 6%-ийн хүүтэй. Компани нь зээлийн эхний хэсэг болох 300 мянган ам.долларыг 2014 оны 7 сарын 31-нд авсан. Үлдсэн 200 мянган ам.долларыг 2014 оны 9 сарын 29-нд авсан ба зээлийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан. 2016 оны 1 сарын 29-ний өдөр Зээлийн гэрээний хугацааг 2016 сарын 12 сарын 31 хүртэл дахин сунгасан.

2015 оны 07 сарын 01-ний өдөр Компани нь “Хай Би Ойл” ХК-тай барьцаагүй, богино хугацаатай, 250 мянган ам.долларын нийт дүнтэй, 12 сарын хугацаатай, жилийн 6%-ийн хүүтэй хөрөнгө оруулалтын зээлийн гэрээг байгуулсан. Компани нь зээлийн хөрөнгийг Могул Поверт төлөх өрөө төлөхөд ашигласан.

Хай Би Ойл ХК нь 2019 оны 03 сарын 28-ны өдөр энэхүү зээлийг хуримтлагдсан хүүгийн хамт компанийн энгийн хувьцаанд хөрвүүлэхээр шийдвэрлэсэн (Тэмдэглэл 40-ийг харна уу).

Эдгээр зээлүүдийн гэрээний хугацаа дууссан ба 2018 оны 12 сарын 31-ний байдлаар зээлийн үндсэн болон хүүгийн өглөгүүд нь 1,756,220 болон 430,498 мян.төг (2017: 1,612,828 болон 298,579 мян.төг) тус тус байсан.

(vii) ХОТ Холдинг С.а.р.л (хуучин 2-Пак Ресурсэс Инвестмэнт С.а.р.л)-н хөрвөх зээл

2012 оны 11 сарын 12-нд Нако Түлш ХК болон 2-Пак Ресурсэс Инвестмэнт С.а.р.л нар нь 500 мянган ам доллар хүртэлх зээлийг, жилийн 10%-ийн хүүтэй, хугацааны эцэст хэсэгчлэн болон бүхэлдээ хувьцаанд хөрвөх нөхцөлтэй зээлийн гэрээг хоёр жилийн хугацаатай байгуулсан. Хөрвөх зээлээс Охин компанийн ашигласан нийт үндсэн зээлийн дүн нь 2013 оны 12 сарын 31-ний байдлаар 400 мянган ам.доллар. 2014 оны 8 сарын 15-нд Охин компани нь нэмж 50 мянган ам.долларын зээл авснаар нийт зээлийн үлдэгдэл 450 мянган ам.доллар болсон. Зээлийн хугацаа 2014 оны 11 сарын 12-нд дууссан боловч 1-р Нэмэлт өөрчлөлтөөр зээлийн хугацааг ижил нөхцөлтэйгөөр 1 жилээр сунгасан. Өмнөх сунгасан хугацаа нь 2015 оны 11 сарын 12-нд дууссан боловч 2-р болон 3-р Нэмэлт өөрчлөлтөөр тус бүр 1 жилээр сунгасан. Харин нэмэлт өөрчлөлтөөр зээлийн хүүг жилийн 15% болгосон ба зээлдүүлэгчийн нэр нь ХОТ Холдинг С.а.р.л болон өөрчлөгдсөн. Энэ нь мөн Охин компанийн холбоотой тал болно. 2-р Нэмэлт өөрчлөлтөөр шинэчлэгдсэнээс бусад зээлийн нөхцөлүүд хүчин төгөлдөр хэвээр үлдсэн. Өмнөх сунгасан хугацаа нь 2016 оны 11 сарын 12-нд дууссан боловч 3-р Нэмэлт өөрчлөлтөөр дахин төсөл 6 сараар сунгасан. 3-р Нэмэлт өөрчлөлтөөр шинэчлэгдсэнээс бусад зээлийн нөхцөлүүд хүчин төгөлдөр хэвээр үлдсэн. 4 болон 5-р нэмэлт өөрчлөлтөөр зээлийн хугацааг 2018 оны 12 сарын 31 хүртэл сунгасан ба зээлдэгчийн нэрийг Говь Караван ХХК болгон өөрчилсөн.

(viii) МУ-ын иргэн Ч.Оргилболдоос авсан зээл

2018 оны 11 сарын 07-ны өдөр компанийн холбоотой тал болох МУ-ын иргэн Ч.Оргилболдоос 930,000 ам.долларын барьцаагүй, хугацаагүй, хүүгүй зээлсэн. Зээлийн хөрөнгийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд зарцуулсан.

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр зээлийн үлдэгдэл 1,518,878 мян.төг (2017: 0 төг) байна.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

28. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ (үргэлжлэл)

(ix) МУ-ын Хөгжлийн банкнаас авсан зээл

2018 оны 08 сарын 07-ны өдөр Компани нь Монгол Улсын Хөгжлийн Банктай 6 сарын хугацаатай, 7.05%-ийн хүүтэй, 264 сая иений ЗГ-ШГ-З 2018-128 тоот зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн гэрээний дагуу зээл нь алт олборлолтын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой.

2018 оны 11 сарын 30-ны зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт хийн зээлийн хугацааг 2019 оны 11 сарын 13-ны өдөр хүртэл сунгасан. Зээлийн барьцаанд дараах хөрөнгүүдийг барьцаалсан.

№	Барьцааны зүйл	Барьцаа хөрөнгийн Байршил	Улсын бүртгэлийн дугаар	Хөрөнгийн үнэлгээ
1	Бульдозер D-9	Дархан Уул аймаг, Шарын гол сум, Шарын гол ХК-ийн нүүрсний уурхайд ажилладаг техникүүд	1821 УН	205,830
2	Комацу HD-465 гp№38		0303 ТТА	229,812
3	Комацу HD-465 гp№39		0301 ТТА	229,812
4	Комацу HD-465 гp№40		0304 ТТА	229,812
5	Комацу HD-465 гp№41		0322 ТТА	229,812
6	Комацу HD-465 гp№42		0321 ТТА	229,812
7	Комацу HD-465 гp№43		0320 ТТА	229,812
8	Комацу HD-465 гp№44		0323 ТТА	229,812
9	Комацу HD-465 гp№37		0302 ТТА	229,812
10	Өрөм Di-550		7119 УН	215,657
11	Белаз 7555В Гp№57		0149 ТТА	150,480
12	Белаз 7555В Гp№54		0140 ТТА	150,480
13	Белаз 7555В Гp№53		0098 ТТА	150,480
14	Белаз 7555В Гp№51		0148 ТТА	150,480
15	Белаз 7555В Гp№52		0096 ТТА	150,480
16	Белаз 7555В Гp№55		0150 ТТА	150,480
17	Белаз 7555В Гp№56		0147 ТТА	150,480
18	Белаз 7555В Гp№58		0151 ТТА	150,480
19	Грейдер G-655		5327 УН	133,392
20	Komatsu-D375		9025 УН	182,419
Хөдлөх хөрөнгийн нийт үнэлгээ				3,779,635
1	Нэгдсэн засварын газрын барилга 12,700м2 талбайтай	Дархан уул аймаг Шарын гол сум, Шарын гол ХК-ийн нүүрсний уурхай болон Шарын гол суманд байрладаг үл хөдлөх эд хөрөнгүүд.	Y-2001000934	474,275
2	Дархан Уул аймаг, Шарын гол сум, Хайрхан баг Тосгон 1-42тоот 457 м2 талбайтай		Y-2001001162	154,855
3	Авто граж хэсгийн барилга 5616 м2 талбайтай		Y-2001000938	128,061
4	Төмөр замын хэсэг граж, засвар дохиолол байр, диспечер 4374 м2 талбайтай		Y-2001000939	102,087
5	Нүүрс ангиллын ачих дамжлагын байр 4223м2 талбайтай		Y-2001000935	126,583
6	Конторын барилга 2592 м2 талбайтай		Y-2001000940	526,477
7	Лаборатор буюу үйлчлэх комбинатын хэсгийн барилга 4711 м2 талбайтай		Y-2001000936	446,873
8	Амины орон сууц Дархан Уул аймаг, Дархан сум, 14-р баг 2-р хороолол, 12-6 тоот 106м2 талбайтай	Дархан уул аймаг, Дархан сум	Y-2003014007	118,077
Үл хөдлөх эд хөрөнгийн нийт үнэлгээ				2,077,289
Барьцаа хөрөнгийн нийт үнэлгээ				5,856,923

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

29. САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ӨГЛӨГ

“Ти Ди Би Лизинг” ХХК – Санхүүгийн түрээс

2017 оны 7 сарын 06-нд экскаваторыг үйл ажиллагаандаа ашиглахаар Групп нь санхүүгийн түрээсийн гэрээг “ТДБ Лизинг” ХХК-тай байгуулсан. Групп нь 55.6 мянган долларыг сар бүр төлөх бөгөөд түрээсийн хугацааны эцэст түрээсийн хөрөнгийн үнийн 30% буюу 353,1 мянган долларыг төлөх эсвэл тухайн үнийг 12 сарын хугацаанд тэнцүү төлөх гэсэн нөхцөлтэйгөөр хөрөнгийн эзэмшил шилжих сонголттой байсан ба групп нь нэг жилийн хугацаагаар сунгаж, сар бүр 31,3 мянган долларыг төлөхөөр болсон.

2018 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн түрээсийн үндсэн болон хүүгийн өглөгүүд нь 558,850 мян.төг болон 1,047 мян.төг (2017: 1,712,127 болон 3,148 мян.төг) байсан.

“Ти Ди Би Лизинг” ХХК – Санхүүгийн түрээс

2018 оны 08 сарын 01-нд HITACHI ЭКСКАВАТОР ZX870-ыг үйл ажиллагаандаа ашиглахаар групп нь санхүүгийн түрээсийн гэрээг “ТДБ Лизинг” ХХК-тай байгуулсан. Групп нь сар бүр гэрээнд заагдсан төлбөрийг төлөх ба санхүүгийн түрээс нь 2020 оны 08-р сарын 10 нь хүртэл төлөгдөх нөхцөлтэй.

2018 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн түрээсийн үндсэн болон хүүгийн өглөгүүд нь 1,424,434 мян.төг болон 2,348 мян.төг байсан.

“Ди Би Эм Лизинг” ХХК – Санхүүгийн түрээс

2018 оны 10 сарын 19-нд ЭКСКАВАТОР 1900-6-ыг үйл ажиллагаандаа ашиглахаар групп нь санхүүгийн түрээсийн гэрээг “Ди Би Эм” ХХК-тай байгуулсан. Групп нь сар бүр гэрээнд заагдсан төлбөрийг төлөх ба санхүүгийн түрээс нь 2020 оны 05-р сарын 20 нь хүртэл төлөгдөх нөхцөлтэй.

2018 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн түрээсийн үндсэн болон хүүгийн өглөгүүд нь 3,715,299 мян.төг болон 8,397 мян.төг байсан.

2013 “Эбердигм” ХХК – Санхүүгийн түрээс

2013 оны 12 сарын 15-нд Групп нь “Эбердигм” ХХК-тай Группийн одоогийн үйл ажиллагаанд ашиглахаар гурван (3) автосамосвал түрээслэхээр хоёр (2) жилийн, үл цуцлах санхүүгийн түрээсийн гэрээ байгуулсан. Уг түрээсийн гэрээ нь тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд оруулсан өдрөөс эхэлнэ.

Дээр дурдсан санхүүгийн түрээсийн нөхцөл дараах байдалтай байна:

- а) Эхний гурван (3) сарын түрээсийн төлбөр нь 111.9 сая төгрөг.
- б) 7 дэх сараас 10 дахь сар хүртэлх хугацаанд төлбөрийн уян хатан нөхцөлтэй
- в) 11 дэх сараас 16 дахь сар хүртэлх хугацааны сарын түрээсийн төлбөр нь дунджаар 242.5 сая төгрөг.
- г) 17 дахь сараас 24 дэх сар хүртэлх хугацааны сарын түрээсийн төлбөр нь 123.3 сая төгрөг байна.
- д) Мөн санхүүгийн түрээсийн гэрээнд заасны дагуу түрээсийн хугацаа дуусгавар болсноор түрээсийн хөрөнгийг өмчлөх эрх Группт шилжинэ.

Тус санхүүгийн түрээсийн хөрөнгийн зориулалт, ашиглалттай холбоотойгоор хөрөнгийг буцааж, өмнөх онуудад төлсөн түрээсийн үндсэн төлбөрүүдийн 50%-ийг буюу 622,686 мян.төг-г групп нь буцаан авсан.

2018 оны 12 сарын 31-ний байдлаар санхүүгийн түрээсийн үндсэн болон хүүгийн өглөгүүд нь 0 (2017: 1,794,734 болон 200,745 мян.төг) байсан.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

29. САНХҮҮГИЙН ТҮРЭЭСИЙН ӨГЛӨГ (үргэлжлэл)

Тайлант хугацааны санхүүгийн түрээсийн хөдөлгөөн

	2018 оны 01 сарын 01 мян.төг	Төлсөн мян.төг	Цуцалсан мян.төг	Нэмж авсан мян.төг	Валютын Ханш мян.төг	2018 оны 12 сарын 31 мян.төг
“Ти Ди Би Лизинг” ХХК	1,712,127	(1,210,500)		-	57,222	558,849
“Ти Ди Би Лизинг” ХХК	-	(677,467)		2,005,715	96,187	1,424,435
“Ди Би Эм” ХХК	-	(2,042,926)		5,582,858	175,367	3,715,299
“Эбердигм” ХХК	1,794,735	-	(1,794,735)	-	-	-
Санхүүгийн түрээсийн дүн	3,506,862	(3,925,753)	(1,794,735)	7,583,433	328,776	5,698,583

Тайлант хугацааны санхүүгийн түрээсийн хүүгийн хөдөлгөөн

	2018 оны 01 сарын 01 мян.төг	Төлсөн мян.төг	Цуцалсан мян.төг	Хүү мян.төг	2018 оны 12 сарын 31 мян.төг
“Ти Ди Би Лизинг” ХХК	3,148	(127,134)	-	125,033	1,047
“Ти Ди Би Лизинг” ХХК	-	(57,463)	-	59,811	2,348
“Ди Би Эм” ХХК	-	(47,391)	-	55,789	8,398
“Эбердигм” ХХК	200,745		(200,745)	-	-
Санхүүгийн түрээсийн хүүгийн дүн	203,893	(231,988)	(200,745)	240,632	11,792

30. САНГУУД

а) Уурхайн нөхөн сэргээлтийн сан

Групп нь уурхайн талбайн нөхөн сэргээлтийн ирээдүйн зардалд хямдруулсан сууриар бүрэн нөөц байгуулсан. Дахин сэргээлтийн нөөц нь 2035 он хүртэл гарахаар хүлээгдэж буй холбогдох нөхөн сэргээлтийн зардлын өнөөгийн үнэ цэнийг илэрхийлдэг. Одоогийн эдийн засгийн орчинд үндэслэсэн төсөөллийг ашиглан ирээдүйн өр төлбөрийг тооцоолсон. Эдгээр төсөөллийг санг материаллаг байдлаар өөрчлөхөд үед тогтмол хянаж байдаг.

Гэсэн хэдий ч, бодит нөхөн сэргээлтийн зардал нь шаардлагатай сэргээх ажлын ирээдүйн зах зээлийн үнээс хамаарах бөгөөд үүнд тухайн хугацааны зах зээлийн нөхцөл байдал нөлөөлнө. Мөн, нөхөн сэргээлтийн хугацаа нь эдийн засгийн боломжит түвшнүүдэд уурхайн үйлдвэрлэл зогсох үеэс шалтгаалах магадлалтай. Энэ нь угийн тодорхойгүй байдаг ирээдүйн нүүрсний үнээс шалтгаална.

	Групп		Компани	
	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
1 сарын 1	11,330,472	8,070,438	11,330,472	8,070,438
Өөрчлөлт	14,005	755,162	14,005	755,162
Капиталжуулалт	(831,405)	2,504,872	(831,405)	2,504,872
12 сарын 31	10,513,072	11,330,472	10,513,072	11,330,472

2018 оны 12 сарын 31-нээрх нөөцийн тооцоололд ашигласан хөнгөлөлтийн түвшин нь 10.21% (2017: 6.3%).

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

30. САНГУУД (үргэлжлэл)

б) Ажилчдын тэтгэврийн сан

2018 оны 11-н сард хамтын хэлэлцээрийн дагуу тэтгэмж олгох журам өөрчлөгдсөн ба Шарын Гол ХК-ийн үйлдвэрчний эвлэлийн хамтын хэлэлцээрийн 6.2.1-д зааснаар компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож байгаа ажилтанд тухайн компанид ажилласан жил тутамд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоон тэтгэмжийг нэг удаа компаниас олгодог болж өөрчлөгдсөн.

Групп нь ажилчдыг төлөөлөн үйлдвэрчний эвлэлийн хороотой тэтгэврийн дараах хөтөлбөрийн нөхцөлийг тохиролцон тогтмол хугацаанд хэлэлцдэг. Ажилчдын тэтгэврийн сангийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход 6.068%-ийн хорогдуулсан хувь хэмжээ ашигласан. Энэхүү хөтөлбөр нь санхүүжигдээгүй болно.

	Групп		Компани	
	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
01 сарын 01	1,234,411	947,935	1,234,411	947,935
Одоогийн үйлчилгээний өртөг-Удирдлага	94,366	34,055	94,366	34,055
Одоогийн үйлчилгээний өртөг-Уурхайн ажилчид	915,764	215,580	915,764	215,580
Хүүгийн зардал	122,066	100,113	122,066	100,113
Тэтгэврийн төлөлт	(88,896)	(63,272)	(88,896)	(63,272)
12 сарын 31	2,277,711	1,234,411	2,277,711	1,234,411

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

31. ХУДАЛДААНЫ БОЛОН БУСАД ӨГЛӨГ

	Тэм	Групп		Компани	
		2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Гуравдагч талд өгөх худалдааны өглөг		2,044,684	3,119,784	2,044,684	3,071,373
Холбоотой талд өгөх худалдааны өглөг	37	918,324	315,190	959,414	186,419
Бусад татварын өглөг		4,607,472	3,648,825	4,212,358	3,590,669
ЭМНДШ-ийн өглөг		386,575	426,201	331,781	370,581
Цалингийн өглөг		597,889	549,734	597,889	494,198
Бусад		588,648	92,317	588,648	76,359
		9,143,592	8,152,051	8,734,774	7,789,599

32. ГЭРЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР

	Групп		Компани	
	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Гэрээний өр төлбөр	2,356,410	20,560	2,356,410	20,560
12 сарын 31	2,356,410	20,560	2,356,410	20,560

	Гэрээний өр төлбөр			
	Групп		Компани	
	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
Гэрээний үлдэгдэл				
1 сарын 1	20,560	36,083	20,560	36,083
Тайлант хугацаанд гэрээний өр төлбөрөөс хүлээн зөвшөөрсөн орлого	(13,801,495)	(561,082)	(13,801,495)	(561,082)
Тайлант хугацаанд мөнгөөр хүлээн зөвшөөрсөн орлогоос хэтэрсэн орлого	(499,469)	(33,946)	(499,469)	(33,946)
Тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй гүйцэтгэлд урьдчилж авсан мөнгө	16,636,816	579,504	16,636,816	579,504
12 сарын 31	2,356,410	20,560	2,356,410	20,560

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

32. ГЭРЭЭНИЙ ӨР ТӨЛБӨР (үргэлжлэл)

Дээрх гэрээнүүдэд заасан эдгээр биелүүлээгүй байгаа гүйцэтгэлийн үүргүүд хангагдах үед буюу ирээдүйн тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэгдэх орлогын шинжилгээ нь дараах байдалтай байна.

2018 оны 12 сарын 31	2019 мян.төг	2019 оноос хойш мян.төг	Нийт мян.төг
Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн гэрээ	2,327,690	-	2,327,690
Дарханы төмөрлөрийн үйлдвэр ХК-ийн гэрээ	9,541	-	9,541
Бусад харилцагчдын гэрээ	19,179	-	19,179
	2,356,410	-	2,356,410

2017 оны 12 сарын 31	2018 мян.төг	2018 оноос хойш мян.төг	Нийт мян.төг
Л.Батсайхан	2,179	-	2,179
УБ Сигнэт ХХК	2,640	-	2,640
Бусад харилцагчдын гэрээ	15,741	-	15,741
	20,560	-	20,560

33. ОРЛОГЫН ТАТВАРЫН ӨГЛӨГ

	Групп		Компани	
	2018 он мян.төг	2017 он мян.төг	2018 он мян.төг	2017 он мян.төг
1 сарын 1	681,151	(82,019)	679,720	(83,147)
Нэмж ногдуулсан-ААНОАТ	338,126	720,024	280,093	720,024
Нэмж ногдуулсан-Суутган татвар	307,226	-	307,226	-
Нэмж ногдуулсан-Хүүгийн орлогод	5,190	303	4,324	-
Төлөгдсөн татвар	(500,000)	(100,000)	(500,000)	(100,000)
Охин компани дах хяналтаа алдах үеийн устгах бичилт	(205)	142,843	-	142,843
12 сарын 31	831,488	681,151	771,365	679,720

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

а. Гадаад валютаарх ажил гүйлгээ

Группийн тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг юм. Группийн үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол Улсын Төгрөг болно.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөөрх хөрөнгө, өр төлбөрийг тайлагнах валют (Төгрөг) руу хөрвүүлэхдээ балансын өдрийн албан ханшаар, гадаад валютаар илэрхийлэгдсэн орлого, зарлагуудыг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлсэн.

Эдгээр хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз ба гарзыг орлогын тайланд тусгасан.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг түүхэн өртгөөр нь илэрхийлж гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлсэн.

Тайлант жилийн явцад хэрэглэж байсан ханш дараах байдалтай байна:

	Дундаж ханш		Хаалтын ханш	
	2018 он	2017 он	2018 он	2017 он
Ам.доллар ба төгрөг	2,472.13	2,439.38	2,642.92	2,427.13
Евро ба төгрөг	2,919.65	2,754.03	3,024.65	2,897.87
Иен ба төгрөг	22.39	21.75	23.98	21.53

б. Бизнесийн нэгдэл ба гүүдвилл

Бизнесийн нэгдлийг бүртгэхдээ худалдан авалтын нягтлан бодох бүртгэлийн аргыг ашиглана. Худалдан авалт хийхэд зарцуулж буй өртөг нь хүлээн авсан зүйлийн худалдан авалтын өдрийн бодит үнэ, худалдагдаж буй компани дахь хяналтын багцын ашиг сонирхол ороогүй дүнгийн нийлбэр байна.

Бизнесийн нэгдлийн үед Групп нь худалдагдаж буй компани дахь хяналтын бус багцын дүнг бодит үнээр нь үнэлэх, эсвэл худалдагдаж буй талын тодорхойлох боломжтой цэвэр хөрөнгийн дүнтэй хувь тэнцүүлэн үнэлэх эсэхээ сонгодог.

Бизнесийн нэгдэл хэрэгжих үед, худалдан авагч компанид худалдагдаж буй компани дахь өөрийн хөрөнгийн ашиг сонирхол нь худалдан авалтын өдрөөр, бодит үнээр дахин үнэлэгдэж, орлого эсвэл зарлагаар хүлээн зөвшөөрөгдөнө. Үүнийг гүүдвиллыг тодорхойлоход харгалзаж үзнэ.

Худалдан авагч компанийн шилжүүлэх аливаа болзошгүй төлбөрийг худалдан авалтын өдрөөр бодит үнээр хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө эсвэл өр төлбөрөөр ангилсан болзошгүй төлбөр нь санхүүгийн хэрэглүүр бөгөөд НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилтийн хүрээнд хамаарах бөгөөд бодит үнэ цэнээр үнэлэх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийг орлого, зардлын дансанд эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын өөрчлөлтөөр хүлээн зөвшөөрнө. Хэрэв болзошгүй төлбөр нь НББОУС 39 - хамаарахгүй тохиолдолд зохих СТОУС-ийн дагуу үнэлнэ. Болзошгүй төлбөрийг өөрийн хөрөнгөнд ангилсан бол дахин үнэлэхгүй бөгөөд дараа хийгдэх тооцоог өөрийн хөрөнгөнд хамаарна.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

б. Бизнесийн нэгдэл ба гүүдвилл (үргэлжлэл)

Гүүдвиллыг анхлан хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь буюу, тодорхойлогдох боломжтой хөрөнгө ба тооцоолсон өр төлбөрийн цэвэр дүнгээс шилжүүлсэн төлбөр, хяналтын бус багцын хувь оролцоонд хүлээн зөвшөөрсөн дүн ба өмнө нь эзэмшсэн хувь оролцооны нийлбэрийн илүү гарсан хэсгээр хүлээн зөвшөөрнө. Хэрвээ төлбөрийн дүн нь цэвэр хөрөнгийн бодит үнээс илүү байвал Групп нь олж эзэмшиж буй бүх хөрөнгө болон тооцсон бүх өр төлбөрийг зөв тодорхойлсон эсэхийг дахин үнэлж, худалдан авалтын өдөр хүлээн зөвшөөрөх дүнг хэмжих процедуруудыг шалгана. Дахин үнэлсний эцэст цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнийн дүн нь шилжүүлсэн төлбөрүүдийн нийт дүнгээс илүү хэвээр байвал олзыг ашиг, алдагдлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Анхлан хүлээн зөвшөөрсний дараа гүүдвиллийг, өртгөөс хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр бүртгэнэ.

Гүүдвилл нь мөнгөн урсгал үүсгэгч нэгжийн нэг хэсгийг бүрдүүлж байгаа ба уг нэгжийн үйл ажиллагааны нэг хэсгийг борлуулсан тохиолдолд, энэ үйл ажиллагааны борлуулалтын олз, гарзыг тодорхойлохдоо борлуулсан үйл ажиллагаатай холбогдох гүүдвиллийг борлуулсан үйл ажиллагааны бүртгэлийн дүнд оруулж тооцно. Энэ нөхцөлд борлуулсан гүүдвиллийг борлуулсан үйл ажиллагаа, мөнгөн урсгал үүсгэгч нэгжийн борлуулалтыг авч үлдсэн хэсгийн үнэд хувь тэнцүүлэн хэмжинэ.

с. Орлого хүлээн зөвшөөрөлт

i) Нүүрсний борлуулалт

Нүүрсний борлуулалтыг өмчлөх эрхийг худалдан авагчид нь шилжсэн үед үүсэж байгаа өмчлөлтэй холбоотой томоохон эрсдэл, өгөөж нь шилжсэн үед хүлээн зөвшөөрнө. Энэ нь ихэнхдээ бүтээгдэхүүн биетээр галт тэрэг, конвейер эсвэл өөр бусад тээвэрлэгч механизмд ачигдах үед үүснэ.

ii) Алтны орлого

Алтыг борлуулалтыг олборлосон алтаа Монгол банкинд цэвэр хүндийн жингээр нь тушаасан үед орлогоор хүлээн зөвшөөрнө.

iii) Хүүгийн орлого

Хорогдуулсан өртгөөр хэмждэг санхүүгийн бүх хэрэглүүр болон борлуулахад бэлэн гэж ангилсан хүү тооцдог санхүүгийн хөрөнгийн хувьд, хүүгийн орлогыг шаардлагатай үед санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн бүртгэлийн дүнтэй цэвэршүүлсэн богино хугацааны буюу санхүүгийн хэрэглүүрийн таамагласан хугацаанд тооцоолсон, ирээдүйд хүлээж авах буюу төлөх мөнгөн урсгалын бууруулсан хүүгийн түвшнийг ашигласан үр ашигт хүүгийн аргад үндэслэн хүлээн зөвшөөрнө. Хүүгийн орлогыг нэгтгэсэн орлогын тайлангийн санхүүгийн орлогод бүртгэнэ.

iv) Түрээсийн орлого

Үйл ажиллагааны түрээс гэж ангилсан түрээсээс олсон орлогыг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

v) Үзүүлсэн үйлчилгээ, кафе болон туслах эх үүсвэрийн орлого

Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой болон бусад үйл ажиллагаанаас олсон орлогыг бараа, ажил үйлчилгээг харилцагчид шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

d. Өртөг/ Зардал хүлээн зөвшөөрөлт

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардал нь тайлант хугацааны үед өөрийн хөрөнгийг бууруулж буй хөрөнгө оруулагчдад олгосон хуваарилалтаас бусад эдийн засгийн өгөөжийн гадагшлах үрсгал, хөрөнгийн бууралт, мөн өр төлбөрийн нэмэгдэл зэрэг болно. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг ба зардлыг гарсан үед нь нэгтгэсэн орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

e. Санхүүгийн орлого/(зардал)

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтад бодогдсон хүүгийн орлогыг хамааруулна. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн орлого олсон тайлант үеийнх нь нэгтгэсэн орлогын тайланд тусгана.

Санхүүгийн зардалд зээлийн хүүгийн зардал хамааруулна. Капиталжуулах шаардлагыг хангасан хөрөнгийн худалдан авалт, барилгын ажил эсвэл үйлдвэрлэлтэй шууд хамааралтай капиталжуулагдсан зээлийн өртгөөс бусад бүх зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн гарсан тайлант үеийнх нь орлогын тайланд тусгана.

f. Зээлийн өртөг

Хугацаа шаардсан хөрөнгийн худалдаж авах, барьж байгуулах, үйлдвэрлэхтэй шууд холбоотой зээлийн зардлыг тухайн хөрөнгө иж бүрэн, ашиглахад бэлэн болох хүртэлх хугацаанд капиталжуулдаг. Тухайн зорилгоор авсан зээлтэй холбоотой хүүгийн түвшин эсвэл Группийн зээлийн ерөнхий эх үүсвэр нь ашиглагдаж буй бол жигнэсэн дундаж хүүгийн түвшнээр санхүүгийн зардлыг капиталжуулдаг.

Зээлийн өртгийн капиталжуулалт нь хөрөнгийн барьж босгох үйл явц зогссон үед дуусдаг. Бусад зээлийн өртөг нь тухайн зардал гарсан үеийн хугацаандаа “Санхүүгийн зардал”-д тайлагнагддаг.

g. Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо анхны өдрийн гэрээний агуулга дээр үндэслэнэ. Гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг, хэдийгээр уг эрхийг гэрээнд тодорхой заагаагүй байсан ч, үнэлж үзэх шаардлагатай.

i) Групп түрээслэгч

Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг дэлгэрэнгүй орлогын нэгтгэсэн тайланд түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн түрээс нь Группийн түрээсэлж байгаа хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотой бараг бүх эрсдэл, өгөөжийг түрээслэгч олж авсныг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү хэмжээгээр хөрөнгө ба өр төлбөрөөр хүлээн зөвшөөрсөн дүн юм. Түрээсийн хамгийн бага төлбөрийг санхүүгийн зардал болон өр төлбөрийн үлдэгдлийг бууруулах дүнд хуваарилна. Санхүүгийн зардлыг өр төлбөрийн үлдэгдэл дүнд тогтмол хуваарь бүхий хүүгийн түвшнийг тогтоохын тулд түрээсийн хугацаа бүрд хуваарилдаг. Болзошгүй түрээс нь тухайн гарсан тайлант хугацаанд зардлаар бүртгэнэ.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

г. Түрээс (үргэлжлэл)

ii) Групп түрээслүүлэгч

Түрээслүүлэгч нь хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байгаа түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Үйл ажиллагааны түрээсийн гэрээг анх байгуулахад гарсан шууд зардлуудыг түрээсэлсэн хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмэх ба түрээсийн хугацаанд түрээсийн орлогыг зөвшөөрөхтэй адил аргаар хүлээн зөвшөөрнө.

h. Татварын зардал

i) Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.

Цэвэршүүлэх хууль ёсны эрхтэй бөгөөд Групп нь цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа эсвэл хөрөнгийг борлуулсан даруйдаа өр төлбөрийг барагдуулах гэж байгаа тохиолдолд л одоо байгаа татварын хөрөнгө, өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрнө. Удирдлага нь НББ-ийг яаж хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахаар тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

ii) Хойшлогдсон орлогын албан татвар

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд “Тайлан тэнцлийн арга”-ыг ашиглан хойшлогдсон орлогын албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон орлогын албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хойшлогдсон орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,

- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

h. Татварын зардал (үргэлжлэл)

ii) Хойшлогдсон орлогын албан татвар

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна. Хүлээн зөвшөөрөөгүй, хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.

Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

iii) Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, орлогод суурилсан татварууд нь орлогын албан татварын шинж чанартай үед НББОУС 12-д заасны дагуу бүртгэнэ. Засгийн газрын агентлагаас ногдуулсан ба төлөх дүн нь үйлдвэрлэсэн тоо хэмжээ эсвэл орлогын хувь хэмжээ дээр суурилсан бус харин түр зөрүүнүүдийг тохируулсны дараах татвар ногдох орлого дээр суурилсан үед НББОУС 12-ын дагуу бүртгэнэ. Ийм зохицуулалтуудын үед өөр татварын хэлбэрүүдийн хувьд өнөөгийн ба хойшлогдсон татваруудыг дээр дурдсаны дагуу бүртгэнэ. Эдгээр шаардлагуудыг хангахгүй байгаа, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн зохицуулалтаас үүссэн үүргүүдэд тайлант хугацаанд сан байгуулж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт оруулна. Группт ногдсон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь эдгээр шаардлагуудыг хангахгүй байгаа учраас орлогын албан татварын нэг хэсэг гэж авч үзэхгүй.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

i. Ажилчдын тэтгэмж

i) Түр хугацааны ажилчдын тэтгэмж

Богино хугацаат ажилчдын тэтгэмж нь хөнгөлөлтгүй сууриар хэмжигддэг бөгөөд ажилчдын ажил гүйцэтгэсэн тайлант үед нь зардлаар бүртгэдэг.

Хэрэв ажилчдын гүйцэтгэсэн ажлын үр дүнгээс үүдэн компани хуулийн дагуу бонус өгөх хариуцлага хүлээх болон бонусын дүнг үндэслэлтэй тооцоолох боломжтой үед тооцоолсон дүнгээр богино хугацаат бонусын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

ii) Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал

Монгол улсын хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд уг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

iii) Урт хугацааны ажилчдын тэтгэмж

Тайлант ба өмнөх үеүд дэх өөрсдийн үйлчилгээнийхээ хариуд ажилчдын олсон тэтгэмжийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийхийн тулд актуар арга зүйг ашигладаг. Энэ нь тайлант ба өмнөх үеүдэд хэдий хэмжээний тэтгэмж хамаарахыг тодорхойлох, тэтгэмжийн зардалд нөлөөлөх хүн ам зүйн болон санхүүгийн хувьсагчдын талаар тооцоолол хийдэг. Тогтоосон тэтгэмжийн үүрэг болон одоогийн үйлчилгээний өртгийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд Төсөвлөсөн Нэгжийн Кредит аргыг ашиглан тэтгэмжийг дискаунчладаг.

j. Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт

Компани нь санхүүжигч талд хяналттай бол тухайн санхүүжигч талыг охин компани гэж ангилна. Дараах хяналтын гурван шалгуурыг бүгдийг нь хангасан тохиолдолд компанийг санхүүжигч талд хяналттай гэж үзнэ. Санхүүжигч талыг зохицуулах эрх мэдэлтэй, санхүүжигч талын үйл ажиллагаанаас төрөл бүрийн өгөөж хүртдэг бөгөөд өөрт буй эрх мэдлээ тухайн өгөөжид нөлөөлөхүйц байдлаар ашиглах чадвартай. Эдгээр хяналтын шалгуур өөрчлөгдсөн байж болзошгүй гэж үзэхэд хүргэсэн баримт, нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналтыг дахин үнэлнэ.

Компани нь санхүүжигч талын саналын эрхийн дийлэнх хувийг эзэмшдэггүй хэдий ч түүний үйл ажиллагааг зохицуулах эрх мэдэлтэй байх тохиолдолд де-факто хяналт оршин байдаг. Де-факто хяналттай эсэхээ тодорхойлохдоо компани дараах зүйлсийг хамарсан бүх баримт, нөхцөл байдлыг авч үзнэ:

- Компанийн эзэмшилд буй саналын эрхийг санхүүжигч байгууллагад саналын эрх эзэмшдэг бусад этгээдүүдийн хэмжээ болон тархалттай харьцуулна
- Компани болон бусад этгээдүүдийн эзэмшдэг боломжит саналын эрх
- Бусад гэрээт хэлэлцээр
- Саналын ирцийн түүхэн хэв маяг.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд охин компанид оруулсан хөрөнгө оруулалт нь охин компаниудын хувьцаат капиталтай цэвэрлэгдэн тайлагнагдана.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

к. Өмч, барилга, тоног төхөөрөмж

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны өртөгт худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг Компанийн зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгоход шаардагдах худалдан авалттай холбоотой зардлууд багтах бөгөөд үүнд мөн холбогдох зээлийн зардлыг оруулдаг.

Өмч, барилга, тоног төхөөрөмжийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрсний дараа үеэс газар ба үл хөдлөх хөрөнгөөс бусад үндсэн хөрөнгийн ангийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр нь хэмжинэ. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлс нь ашиглалтын ялгаатай хугацаатай томоохон бүрэлдэхүүнээс бүрдэж буй тохиолдолд бүрэлдэхүүн хэсгүүдийг барилга, тоног төхөөрөмжийн тусдаа зүйл болгон бүртгэдэг.

Үндсэн хөрөнгийн бүлгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрсний дараа дахин үнэлгээний загвараар хэмжиж, дахин үнэлгээний нэмэгдлийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн.

Дараа үеийн зардал

Сольж тавьсан эд анги, хэсэг нь ирээдүйд эдийн засгийн үр өгөөж компанид өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед Өмч, барилга, тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг тайланд хөрөнгийн дансны үнэнд нэмж хүлээн зөвшөөрнө. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өмч, барилга, тоног төхөөрөмжийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Томоохон урсгал засвар үйлчилгээнүүд

Тухайн эд ангитай холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг компанид авчрах болон өртгийн найдвартай хэмжих боломжтой байх үед дараа үеийн зардлыг хөрөнгийн дансны үнэнд нэмж эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Тухайн тайлант хугацаанд гарсан бусад бүх засвар үйлчилгээний зардлуудыг тухайн зардлыг гарсан тайлант хугацаанд нь орлого үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Олз болон гарз

Өмч, барилга, тоног төхөөрөмжийн зүйлсийг худалдан борлуулснаас үүсэх олз буюу гарз нь дансны үнийг борлуулсан үнэтэй харьцуулж тодорхойлох бөгөөд орлого, үр дүнгийн тайланд өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз, гарзаар бүртгэгдэнэ.

Дуусаагүй барилга

Дуусаагүй барилга нь хараахан дуусгаагүй буюу суурилуулаагүй байгаа барилгын ажлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Барилгын ажлын дууссан хэсэг нь Группийн үйл ажиллагаанд ашиглагдах бөгөөд ашиглалтад орсон хэсгээс бусад дуусаагүй барилгад барилгын болон суурилуулалтын ажлын явцад элэгдэл байгуулдаггүй.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

к. Өмч, барилга, тоног төхөөрөмж (үргэлжлэл)

Элэгдэл

Элэгдэл нь орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд авчирсан буюу ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн бүртгэж эхэлнэ.

Элэгдлийг шулуун шугамын аргаар, доорх тогтоосон ашиглалтын хугацааны турш байгуулдаг:

▪ Барилга болон бусад байгууламж	10-60 жил
▪ Машин, Тоног төхөөрөмж	5-15 жил
▪ Тавилга эд хогшил	10 жил
▪ Компьютер тоног төхөөрөмж	5 жил

Дахин үнэлгээ

Анх хүлээн зөвшөөрч бүртгэсний дараа компани өөрийн хэрэгцээнд ашигладаг барилга байгууламжийг дахин үнэлсэн дүнгээр буюу дахин үнэлгээ хийгдсэн өдрөөрх бодит үнэ цэнээс аливаа хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн бусад ангиллуудын хувьд өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр бүртгэнэ. Хэрэв барилга байгууламжийн дансны дүн нь дахин үнэлгээний үр дүнд өссөн бол, дансны дүнгийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч, өмчийн хэсэгт дахин үнэлгээний нөөцөөр хуримтлуулан бүртгэнэ. Хэрэв тухайн барилга байгууламжийн дансны дүн нь дахин үнэлгээний үр дүнд буурсан бол дахин үнэлгээний бууралтыг зардлаар бүртгэнэ.

Дахин үнэлгээний нэмэгдэл нь дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийг худалдан борлуулах эсвэл данснаас хасах үед дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэнд тооцож хуримтлагдсан ашигт хаана.

I. Биет бус хөрөнгө

Олж бэлтгэсэн болон дотооддоо хөгжүүлсэн, үйлдвэрлэл болон удирдлагын түвшинд ашиглагдах програм хангамж нь Биет бус хөрөнгөнд багтана. Биет бус хөрөнгүүдийг өртгийн загвараар бүртгэх бөгөөд ашиглалтын хугацаа нь тодорхой хөрөнгүүдийн тогтоосон ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэгдэл өртөг болон ашиглалтын хугацааг санхүүгийн тайлангийн үе бүрд шалгадаг. Биет бус хөрөнгийн тогтоосон ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна. Үүнд:

Программ хангамж:

Ашиглалтын хугацаа
5 жил

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

м. Хойшлуулсан хайгуул ба үнэлгээний хөрөнгө

i) Лицензийг олж эзэмшихээс өмнөх үеийн зардлууд

Лицензийг олж эзэмшихээс өмнөх үеийн зардал нь Групп тухайн газарт хайгуул хийх хуулийн дагуу эрхийг олж авахаас өмнөх зардлуудыг хамрана. Эдгээр зардлуудад хайгуулын мэдээллийг олж эзэмших болон уг мэдээллийг шинжлэхтэй холбоотой зардлууд орж болно. Эдгээр зардлуудыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

ii) Хайгуул болон үнэлгээний зардлууд

Хайгуул болон үнэлгээний үйл ажиллагаанд ашигт малтмалын нөөцийг хайх, техникийн үндэслэлийг тодорхойлох, тогтоосон нөөц борлогдох чадварын үнэлгээ багтана.

Хайгуул, үнэлгээний үйл ажиллагаанд:

- Хайгуулын түүхэн мэдээллийг судлах, шинжлэх
- Геофизикийн судалгаагаар хайгуулын мэдээллийг цуглуулах
- Хайгуулын өрөмдлөг болон дээж авах
- Нөөцийн хэмжээ болон түвшинг тодорхойлох, шинжлэх
- Тээврийн болон дэд бүтцийн хэмжилт хийх
- Зах зээл болон санхүүгийн судалгааг явуулах

Одоо байгаа хайгуулын талбайн хайгуулын эрхтэй холбоотойгоор төлсөн лицензийн зардлуудыг капиталжуулах ба зөвшөөрлийн хугацаанд хорогдуулна. Хайгуул хийх хууль ёсны эрхтэй болсны дараа Захирлууд ирээдүйн эдийн засгийн өгөөжийг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэхээс бусад тохиолдолд хайгуул, үнэлгээний зардлыг капиталжуулна. Эдгээр зардалд шууд хамааралтай ажилчдын цалин тэтгэмж, ашигласан материал, шатахуун, судалгаа болон өрөмдлөгийн зардал, гэрээт талуудад төлсөн төлбөр, хайгуулын талбайн нөхөн сэргээлт болон сэргээлтийн капиталжуулсан зардлууд орно. Тухайн сонирхол бүхий газар дээр гарсан ирээдүйд шилжүүлэн тооцох зардал нь хүчингүй болж төсөл зогсох үед тухайн зардал орлогын тайланд тухайн жилийн бусад зардал хэсэгт бүртгэгдэнэ.

Хайгуул ба үнэлгээний үйл ажиллагаанаас капиталжуулагдсан зардлууд нь үндсэн хөрөнгө дэх уурхай хөгжүүлэлтийн хөрөнгөөр уурхайг арилжааны зорилгоор ашиглах шийдвэр гарсан үед шилжүүлэн бүртгэнэ.

н. Бараа материал

Бараа материалыг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч дараа үеүдэд өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмжинэ. Бараа материалын өртөгт худалдан авалттай холбоотой бүх зардал, хөрвүүлэлтийн зардал болон бараа материалыг өнөөгийн байршил ба нөхцөлд нь авч ирэхэд гарсан бусад бүх зардал багтана.

Хэвийн харилцан сольж болохуйц зүйлсийн өртгийг тодорхойлоход жигнэсэн дундаж өртгийг хэрэглэдэг.

о. Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг анх өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

р. Худалдан авагчаас нэхэмжлэх дүн

Худалдан авагчаас нэхэмжлэх дүн нь худалдан авагчаас хараахан нэхэмжлээгүй боловч тухайн өдрөөрх гэрээт ажлын гүйцэтгэл бөгөөд худалдан авагчаас авахаар хүлээгдэж буй нийт дүнг илэрхийлнэ. Энэ нь нийт гарсан зардал дээр нэмэх нь тухайн өдрөөрх хүлээн зөвшөөрөгдсөн ашиг, хасах нь гүйцэтгэлийн нэхэмжлэлүүд болон тухайн өдрөөрх хүлээн зөвшөөрөгдсөн алдагдал гэж хэмжигдэнэ. Нийт гарсан зардалд тухайн төсөлд шууд хамааралтай гарсан бүх зардал мөн үйл ажиллагааны хэвийн хүчин чадалд суурилан тооцож, хуваарилсан Группийн үйл ажиллагааны тогтмол ба хувьсах нэмэлт зардлуудыг багтаана.

Худалдан авагчаас нэхэмжлэх дүн нь балансад дансны болон бусад авлагын хэсэгт тайлагнагдана.

Хэрэв харилцагчдаас хүлээн авсан төлбөр нь орлогын тайланд хүлээн зөвшөөрснөөс илүү байвал зөрүү нь худалдан авагчид өгөх өглөг болох ба балансад дансны болон бусад өглөг хэсэгт урьдчилж олсон орлогын адил тайлагнагдана.

q. Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгүүд нь бэлэн мөнгө болон бусад банкны байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

r. Санхүүгийн хөрөнгө

Хөрөнгө худалдан авсан зорилгоос хамаарч Компани нь санхүүгийн хөрөнгөө доор дурдсан байдлаар ангилдаг. Компани дуусах хугацаа хүртэл нь эзэмшсэн санхүүгийн хөрөнгөө ангилаагүй.

Хеджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хөрөнгийг Компани нь дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу ангилна:

Бодит Үнэ Цэнэ нь Ашиг, Алдагдлаар Хэмжигдэх

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөд зөвхөн ашигтай үүсмэл хэрэглүүр багтана (алдагдалтай үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн Өр Төлбөр” хэсгээс харна уу). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн хөрөнгийг Санхүүгийн Байдлын Тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Дэлгэрэнгүй Орлогын Тайлангийн санхүүгийн орлого эсвэл зардлын мөрөнд тусгана. Хеджийн хэрэгслийн зориулалтгүй үүсмэл санхүүгийн хэрэгслээс гадна арилжаалах зорилготой санхүүгийн хөрөнгө Компанид байхгүй бөгөөд Компани санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг сайн дураараа ашиг, алдагдлаар хэмжигдэх ангилалд оруулдаггүй.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

г. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Зээл ба Авлага

Зээл ба авлага гэсэн ангилалд багтах санхүүгийн хөрөнгө нь идэвхтэй зах зээлд арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй үүсмэл бус санхүүгийн хөрөнгө байдаг. Ийм төрлийн санхүүгийн хөрөнгө нь ихэвчлэн харилцагчдад өгсөн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөөцөөр (дансны авлага) дамжиж үүсэх бөгөөд мөн бусад төрлийн гэрээгээр хүлээсэн мөнгөөрх хөрөнгөөс бүрддэг байна. Зээл ба авлагыг бодит үнэ цэнэ дээр нь худалдан авалттай шууд хамааралтай ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрөх ба дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин ашиглан хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр бүртгэнэ.

Компани авлагаа бүгдийг нь цуглуулж чадахгүй гэсэн бодит нотолгоотой (харилцагч санхүүгийн хүндрэлд орох, дампуурах, урт хугацаагаар хойшлуулах) бол үнэ цэнийн бууралтын нөөц үүсгэх ба тухайн нөөцийн үнийн дүнг үнэ цэнийн бууралт үүсгэж буй авлагын дансны цэвэр үнэ болон ирээдүйн таамагласан мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр тооцно. Цэвэр дүнгээр тайлагнагддаг дансны авлагын үнэ цэнийн бууралтыг тусад нь нөөцийн данс үүсгэж, гарзыг нь Орлогын Тайлангийн удирдлагын зардалд тусгана. Дансны авлагыг цуглуулж чадахгүй гэдгийг баталгаажуулснаар хөрөнгийн нийт дансны үнэ цэнийг холбогдох нөөцтэй нь цэвэрлэж данснаас хасна.

Группийн зээл ба авлага нь Санхүүгийн Байдлын Тайлан дахь дансны ба бусад авлагаас бүрддэг.

Мөнгөн хөрөнгө

Кассын үлдэгдэл, банкны хадгаламж, гурван сар ба түүнээс доош дуусах хугацаатай бусад богино хугацаат хөрвөгч хөрөнгө оруулалт болон банкны овердрафт (мөнгөн гүйлгээний тайлангийн зорилготой)-аас мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө бүрдэнэ. Банкны овердрафтыг Санхүүгийн Байдлын Тайлангийн богино хугацаат өр төлбөрийн зээл ба зээллэгт тусгасан.

Борлуулахад Бэлэн санхүүгийн хөрөнгө

Өмнөх ангиллуудад багтаагүй үүсмэл бус хөрөнгийг борлуулахад бэлэн гэсэн ангилалд оруулах ба үүнд ихэвчлэн охин компани, хараат компани, хамтарсан хяналттай аж ахуйн нэгжүүдийн шалгуурыг хангаагүй байгууллагуудад Группийн оруулсан хөрөнгө оруулалт багтдаг. Эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Валютын ханшийн хэлбэлзэл болон үр ашигт хүүгийн түвшин хэрэглэн тооцсон хүүгээс үүссэн өөрчлөлтөөс бусад бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тусгаж, борлуулахад бэлэн нөөцөд хуримтлуулна. Гадаад валютаар илэрхийлэгдсэн бөгөөд хүүг нь үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцдог хөрөнгө оруулалтын ханшийн зөрүүг ашиг, алдагдалд тусгана.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ их хэмжээгээр эсвэл удаан хугацааны турш буурсан бол (үнэ цэнийн бууралт үүссэн гэсэн бодит нотолгоо болно) тухайн үнэ цэнийн бууралтын нийт дүнг өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн үнийн дүнгийн хамт ашиг, алдагдалд тусгана.

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн худалдан авалт, борлуулалтыг төлбөр төлөгдөх өдрөөр хүлээн зөвшөөрнө. Арилжааны өдөр ба төлбөр хийгдэх өдрийн хооронд гарсан үнэ цэнийн бууралтын өөрчлөлтийг борлуулахад бэлэн нөөцөд бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө борлуулах үед борлуулахад бэлэн нөөцөд хуримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдлаар дахин ангилна.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

s. Санхүүгийн Өр төлбөр

Групп өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг. Хеджийн харилцааны шаардлага хангасан санхүүгийн өр төлбөрөөс бусад санхүүгийн өр төлбөрийг Групп нь дараах нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын дагуу ангилна:

Бодит Үнэ Цэнэ нь Ашиг, Алдагдлаар Хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай үүсмэл хэрэглүүр багтана (ашигтай үүсмэл хэрэглүүрийн тухай “Санхүүгийн Хөрөнгө” хэсгээс хар). Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн Байдлын Тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Дэлгэрэнгүй Орлогын Тайланд тусгана. Групп ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах (хедж) зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж, гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд Компанид арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад Санхүүгийн Өр Төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана:

- Банкны зээл болон Группийн хугацаагүй давуу эрхтэй хувьцааг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшин хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмждэг. Ингэснээр Санхүүгийн Байдлын Тайлангаарх өр төлбөрийн үлдэгдэлд хүүгийн зардлыг эргэн төлөлтийн хугацаанд тогтмол хувиар тооцоолох боломжийг олгодог. Санхүүгийн өр төлбөрийн хүүгийн зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү эсвэл купон багтана.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүгийн түвшин хэрэглэн хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

t. Үнэ цэнийн бууралт

Өмч, барилга, тоног төхөөрөмж, биет бус хөрөнгө зэрэг бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэ нь эргэн нөхөгдөхгүй байж болохыг илэрхийлсэн үйл явдал буюу өөрчлөлт тухайн нөхцөлд байгаа эсэхийг шалгаж үзэх ёстой. Хөрөнгийн дансны үнэ нь эргэн нөхөгдөх дүнгээс (ашиглалтын үнэ ба бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан дүнгээс их) давсан үед хөрөнгийг бууруулах бичилт хийдэг.

Тухайлсан хөрөнгийн эргэн нөхөгдөх үнийг тооцоолох боломжгүй байх тохиолдолд хөрөнгүүдийг бие даан тодорхой мөнгөн урсгал бий болгохгүй хөрөнгийн бүлгийн хамгийн бага нэгж болох хөрөнгийн мөнгө бий болгогч нэгжийн хувьд үнийн бууралтыг шалгана.

Гүүдвиллийг холбогдох бизнесийн нэгдлээс өгөөж хүртэхээр хүлээгдэж буй мөнгө бий болгогч нэгжид хуваарилах бөгөөд гүүдвиллийг хянаж удирдах хамгийн доод түвшнийг илэрхийлнэ. Гүүдвиллийн хуваарилагдсан мөнгө бий болгогч нэгжүүдийн хувьд жил бүр үнийн бууралтын тест гүйцэтгэнэ.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

34. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

t. Үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Мөнгө бий болгогч нэгжийн үнийн бууралтын алдагдал нь мөнгө бий болгогч нэгжүүдэд хуваарилагдсан анхны дансны нийт үнийн дүнг бууруулна. Үнэ цэнийн бууралтын алдагдлын үлдэгдэл хэсэг нь бусад хөрөнгийн хамрах мөнгө бий болгогч нэгжүүдэд хувь тэнцүүлэн тооцоологдоно. Дараа үеүдэд бүх хөрөнгийн өмнө нь бүртгэгдсэн үнийн бууралтын гарз байгаа эсэхийг дахин шалгах бөгөөд энэ нь магадгүй удаан хугацаанд оршин тогтнохгүй байж болно. Үнийн бууралтын төлбөрийг хэрвээ мөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүн нь үүний дансны үнээс давсан бол дахин өөрчлөгдөнө.

Үнэ цэнийн бууралтын зардлыг нэгтгэсэн орлого, үр дүнгийн тайлангийн ерөнхий удирдлагын зардалд багтаадаг.

u. Хувьцаат капитал

Хувьцаат капитал нь Группийн гаргасан хувьцааг илэрхийлэх бөгөөд хүлээн авсан дүнгээс хувьцаа гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр хэмжигддэг.

Санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд Группийн гаргасан санхүүгийн хэрэгслүүдийг өмчөөр ангилж бүртгэнэ.

Группийн энгийн хувьцаа нь өмчийн хэрэгслээр ангилагддаг.

v. Дахин үнэлгээний нөөц

Дахин үнэлгээний нөөц нь бүртгэлийн бодлогын дагуу үүссэн, өөрийн хэрэгцээнд ашигладаг барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөцөөс бүрдэнэ.

w. Ногдол ашиг

Ногдол ашгийг түүнийг зарласан тайлангийн хугацаанд өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

x. Худалдааны болон бусад өглөг

Худалдааны болон бусад өглөгүүдийг өртгөөр нь хэмждэг. Бэлэн мөнгө өгөх гэрээт эрх үүсэх буюу өөр аж ахуйн нэгжид санхүүгийн хөрөнгийг хүргэх эрх үүссэн тохиолдолд өглөгийг хүлээн зөвшөөрнө.

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

35. СЕГМЕНТИЙН ТАЙЛАГНАЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайланд дараах үндсэн 2 сегментүүд багтсан. Үүнд:

- **Нүүрс** - Шарын Гол ХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь нүүрс олборлон борлуулах үйл ажиллагаа бөгөөд группийн нийт орлогын 83.8%-ийг (2017: 75.449%) бүрдүүлдэг тул Компанийн бизнесийн томоохон хувийг эзэлдэг.
- **Алт** - Алтны сегмент нь тайлант хугацаанд нийт 80 тн алт олборлосон, борлуулсан ба алтны олборлолтыг охин компани болох Нагай ХХК хийсэн. Алтны сегмент нь группийн нийт орлогын 16.2%-ийг (2017: 24.551%).

Доорх хүснэгтэд сегмент тус бүрийн 2018 оны гол санхүүгийн гүйцэтгэлийг үзүүлэв:

	Нүүрс мян.төг	Алт мян.төг	Нийт мян.төг
Борлуулалтын орлого	40,794,269	10,358,867	51,153,136
Хасах нь: Сегмент хоорондын орлого	-	(2,465,574)*	(2,465,574)
Борлуулалтын өртөг	(35,111,646)	(8,028,902)	(43,140,548)
Хасах нь: Сегмент хоорондын орлого		2,465,574*	2,465,574
Нийт ашиг	5,682,623	2,329,965	8,012,588
Ерөнхий ба удирдлагын зардал			(3,223,697)
Борлуулалт, маркетингийн зардал			(252,587)
Үйл ажиллагааны бус орлого			208,586
Үйл ажиллагааны бус зардал			(4,183,824)
Сегментийн ашиг			561,066
Санхүүгийн орлого			336,383
Санхүүгийн зардал			(5,278,077)
Бусад олз (гарз)			4,298,447
Татварын өмнөх ашиг			(82,181)

-* 2018 оны 04 сарын 01-нээс Нагай ХХК нь алт олборлолтын үйл ажиллагаа явуулж, уг алт олборлолттой холбоотой гарсан бүх зардлыг Шарын Гол ХК-аас нэхэмжилдэг бөгөөд энэхүү дүнд цалин, элэгдэл, машин тоног төхөөрөмжийн түрээс гэх мэт бүх зардлуудыг нэхэмжилсэн болно.

Доорх хүснэгтэд сегмент тус бүрийн 2017 оны гол санхүүгийн гүйцэтгэлийг үзүүлэв:

	Нүүрс мян.төг	Алт мян.төг	Нийт мян.төг
Борлуулалтын орлого	36,856,901	12,018,131	48,875,033
Борлуулалтын өртөг	(34,202,514)	(4,981,989)	(39,184,502)
Нийт ашиг	2,654,387	7,036,143	9,690,530
Ерөнхий ба удирдлагын зардал	-	-	(2,965,659)
Борлуулалт, маркетингийн зардал			(404,138)
Үйл ажиллагааны бус орлого			130,608
Үйл ажиллагааны бус зардал			(1,262,158)
Бусад олз (гарз)			(11,956)
Санхүүгийн зардал			(4,408,628)
Санхүүгийн орлого			2,463,497
Татварын өмнөх ашиг			3,232,097

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

36. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ

Компани 2018 оны 01 сарын 01-нээс эхлэн СТОУС 9, Санхүүгийн хэрэглүүр болон СТОУС 15, Харилцагчтай байгуулсан гэрээний орлого-г мөрдөж эхэлсэн. СТОУС 15-г хэрэгжүүлж орлогын нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулснаар Компани өмнөх жилийн санхүүгийн тайлангаа дахин тайлагнасан. Компани СТОУС 9-г хэрэгжүүлэхдээ зэрэгцүүлсэн үзүүлэлтийг дахин тайлагнахгүй байхаар сонгосон ба ингэснээр өмнөх жилийн дахин тайлагнасан санхүүгийн тайландаа тусгаагүй болно. Харин эдгээр өөрчлөлтүүдийг анх удаа хэрэгжүүлсэн өдрөөр (2018 оны 01 сарын 01) тусгаж өмчийн эхний үлдэгдэлд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Дараах хүснэгтэд санхүүгийн тайланд нөлөө үзүүлж буй санхүүгийн тайлангийн үзүүлэлт түс бүрээр хүлээн зөвшөөрсөн залруулгыг харууллаа:

Залруулга		2017 оны 12 сарын 31	СТОУС 15	2017 оны 12 сарын 31	СТОУС 9	2018 оны 01 сарын 01
		Анх		Дахин тайлагнасан		Дахин тайлагнасан
		тайлагнасан мян.төг		мян.төг		мян.төг
Борлуулалтын орлого	хх	48,950,778	(75,745)	48,875,033	-	48,875,033
Борлуулалтын өртөг		(39,184,502)	-	(39,184,502)	-	(39,184,502)
Нийт ашиг	хх	9,766,276	(75,745)	9,690,531	-	9,690,531
Ерөнхий удирдлагын зардал		(2,965,659)		(2,965,659)	-	(2,965,659)
Борлуулалт, маркетингийн зардал	хх	(479,883)	75,745	(404,138)	-	(404,138)
Үйл ажиллагааны ашиг		6,320,734	-	6,320,734	-	6,320,734
Санхүүгийн орлого		2,463,497		2,463,497	-	2,463,497
Санхүүгийн зардал		(4,408,628)		(4,408,628)	-	(4,408,628)
Үйл ажиллагааны бус орлого		130,608		130,608	-	130,608
Үйл ажиллагааны бус зардал		(1,262,158)		(1,262,158)	-	(1,262,158)
Бусад олз (гарз)		(11,956)		(11,956)	-	(11,956)
Татварын өмнөх ашиг		3,232,097	-	3,232,097	-	3,232,097
Орлогын татварын зардал		(886,734)		(886,734)	-	(886,734)
Тайлант хугацааны цэвэр ашиг/(алдагдал)		2,345,363	-	2,345,363	-	2,345,363
Хувьцаа эзэмшигчид		2,415,791		2,415,791	-	2,415,791
Хяналтын бус багц эзэмшигчид		(70,429)		(70,429)	-	(70,429)
Бусад дэлгэрэнгүй орлого				-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл		31,012		31,012	-	31,012
Дахин үнэлгээний хэрэгжилт		(17,476)		(17,476)	-	(17,476)
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлого		4,704,261	-	4,704,261	-	4,704,261
Хувьцаа эзэмшигчид		2,429,327		2,429,327	-	2,429,327
Хяналтын бус багц эзэмшигчид		(70,429)		(70,429)	-	(70,429)
		2,358,898	-	2,358,898	-	2,358,898

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

36. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ (үргэлжлэл)

Залруулга	2017 оны 12 сарын 31	СТОУС 15	2017 оны 12 сарын 31	СТОУС 9	2018 оны 01 сарын 01
	Анх тайлагнасан		Дахин тайлагнасан		Дахин тайлагнасан
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Хөрөнгө					
Эргэлтийн бүс хөрөнгө					
Өмч, барилга, тоног төхөөрөмж	38,202,509	-	38,202,509	-	38,202,509
Биет бүс хөрөнгө	23,676	-	23,676	-	23,676
Уурхайн хөрөнгө	19,210,960	-	19,210,960	-	19,210,960
Хойшлогдсон татварын хөрөнгө	73,062	-	73,062	-	73,062
Гудвилл	424,990	-	424,990	-	424,990
Эргэлтийн бүс хөрөнгийн нийт дүн	57,935,197	-	57,935,197	-	57,935,197
Эргэлтийн хөрөнгө					
Бараа материал	2,454,418	-	2,454,418	-	2,454,418
Урьдчилж төлсөн зардал ба бусад эргэлтийн хөрөнгө	1,133,409	-	1,133,409	-	1,133,409
Худалдааны болон бусад авлага	6,011,414	-	6,011,414	-	6,011,414
Мөнгөн хөрөнгө	900,181	-	900,181	-	900,181
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	10,499,422	-	10,499,422	-	10,499,422
Нийт хөрөнгийн дүн	68,434,619	-	68,434,619	-	68,434,619
Өр төлбөр ба эздийн өмч					
Өр төлбөр					
Урт хугацаат өр төлбөр					
Урт хугацаат зээл	12,135,650	-	12,135,650	-	12,135,650
Сангууд	12,564,883	-	12,564,883	-	12,564,883
Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн	24,700,533	-	24,700,533	-	24,700,533
Богино хугацаат өр төлбөр					
Урт хугацаат зээлийн богино хугацаанд хамаарагдах хэсэг	338,359	-	338,359	-	338,359
Богино хугацаат зээл	4,243,461	-	4,243,461	-	4,243,461
Богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг	3,506,862	-	3,506,862	-	3,506,862
Хүүгийн өглөг	5,542,227	-	5,542,227	-	5,542,227
Хураамж	146,616	-	146,616	-	146,616
Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн өглөг	33,987	-	33,987	-	33,987
Худалдааны ба бусад өглөг	8,152,051	-	8,152,051	-	8,152,051
Гэрээний өр төлбөр	-	20,560	20,560	-	20,560
Орлогын татварын өглөг	701,711	-	701,711	-	701,711
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	22,665,274	-	22,665,274	-	22,665,274
Эздийн өмч					
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,017,024	-	1,017,024	-	1,017,024
Нэмж төлөгдсөн капитал	23,145,158	-	23,145,158	-	23,145,158
Дахин үнэлгээний нэмэгдэл	10,046,237	-	10,046,237	-	10,046,237
Хуримтлагдсан ашиг	(12,999,320)	-	(12,999,320)	-	(12,999,320)
Цөөнхийн хувь оролцоо	(140,287)	-	(140,287)	-	(140,287)
Эздийн өмчийн нийт дүн	21,068,812	-	21,068,812	-	21,068,812
Өр төлбөр ба эздийн өмчийн нийт дүн	68,434,619	-	68,434,619	-	68,434,619

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

37. ХОЛБООТОЙ ТАЛУУД

Холбоотой талуудыг тодорхойлох

Хэрвээ тухайн компани нь нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтад шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн этгээд нь тухайн Группийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог. Холбоотой талууд нь хувь хүмүүс болон бусад аж ахуйн нэгжүүд байж болно.

Түс Групп нь доор дурдсан аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй холбоотой талууд юм:

Толгой компани	“Шарын Гол”ХК	
Охин компани	“Нагай” ХХК	
Хувь эзэмшигчид	Томоохон Хувь эзэмшигчдийг Тэмдэглэл 1-ээс харна	
Хараат компани	“Нако Түлш” ХК(2018 онд хараат компаниар орж ирсэн.) Шарын Гол Энэрко ХХК	
Холбоотой тал	Фаярбөрд Монголиа Холдингс С.а.р.л, Си Би Эм ХХК, Буман Сарт ХХК, Говь Кораван ХХК, Говь Караван Холдинг ХХК Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л., Хай Би Ойл ХК, Монгол Алтан Минт ХХК, Хэрлэн Онон Туул ББСБ ХХК	
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд	Г. Хулан (ТУЗ-ийн дарга), Б. Батбаатар, Ж.Эрдэмбилэг, Ө. Хишигсүх, Б.Итгэлт, Б.Батмөнх, Жеймс Пассин, М.Батсүрэн, О.Цэндсүрэн	
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх Захирал-(Шарын Гол ХК)	Б. Батбаатар
	Гүйцэтгэх Захирал-(Нагай ХХК)	Ж.Эрдэмбилэг

Холбоотой талд төлөх өглөг болон авах авлага, зээлийн нөхцөлүүд нь Тэмдэглэл 25, 28, 31-т түс түс тайлбарлагдсан болно. Холбоотой талуудад борлуулсан нүүрс болон тэднээс худалдан авсан сэлбэг хэрэгсэл ба шатахууны худалдан авалт нь танил талуудын нөхцөл дээр давамгайлан хийгддэг болно. Холбоотой талуудаас авах авлага эсхүл төлөх өглөгүүдэд ямарваа нэг батлан даалт хийгдээгүй болно. Холбоотой талуудаас авах авлагын үнэ цэнийн бууралт болгон бүртгэсэн. Энэхүү үнэ цэнийн бууралтын үнэлгээ нь жил бүр холбоотой талуудын санхүүгийн байдал болон тэдгээрийн үйл ажиллагаагаа явуулж буй зах зээлийг үнэлэх байдлаар хийгддэг.

Гол удирдах боловсон хүчинтэй хийсэн ажил гүйлгээ

	Үндсэн цалин мян.төг	Нийгмийн даатгал мян.төг
Ерөнхий удирдлага	286,400	37,232
Гүйцэтгэх Удирдлагууд	575,323	74,792
	861,723	112,024

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

37. ХОЛБООТОЙ ТАЛУУД (үргэлжлэл)

Холбоотой талуудтай хийсэн томоохон хэмжээний ажил гүйлгээ нь дараах байдалтай байна:

	Тэм	Борлуулалт болон хүлээн авсан мөнгө		Худалдан авалт болон төлсөн мөнгө		Зээл, зээлийн хүүгийн үлдэгдэл		Авлагын үлдэгдэл		Өглөгийн үлдэгдэл	
		2018 мян.төг	2017 мян.төг	2018 мян.төг	2017 мян.төг	2018 мян.төг	2017 мян.төг	2018 мян.төг	2017 мян.төг	2018 мян.төг	2017 мян.төг
Холбоотой компани:											
Фаярбөрд Эс Эйч Жи Инвестмэнт Лимитед (Лтд)		-	-	-	-	910,528	1,149,313	-	-	-	-
Си Би Эм ХХК		-	-	-	(7,000)	-	-	-	-	155,908	71,085
Буман Сарт ХХК		-	-	(308,980)	(16,000)	-	-	29,652	338,632	-	546
Говь Кораван ХХК -*		-	-	(3,494,708)	(2,952,236)	-	-	237,285	1,137,204	2,973	4,099
Говь Караван Холдинг ХХК		-	-	(22,920)	-	-	-	22,920	-	-	-
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л.		-	-	-	-	-	1,341,508	-	-	-	-
Хай Би Ойл ХК	28	275,311	-	(7,149)	-	2,186,718	1,911,407	-	-	113,376	106,227
Монгол Алтан Минт ХХК		7,300,000	-	(7,300,000)	-	-	-	-	-	35,930	-
Хэрлэн Онон Туул ББСБ ХХК	28	17,557,182	-	(9,462,628)	-	8,094,554	-	-	-	-	-
Ч.Оргилболд	28	2,433,091	-	(914,213)	-	1,518,878	-	-	-	-	-
Могул Паур ХХК -**		-	-	-	-	-	-	-	41,581	-	-
Могул Көүл Холдинг Пте(Лтд) -**		-	-	-	-	-	-	-	-	-	9,108
ХОТ Холдинг С.а.р.л -**		-	-	-	-	-	-	-	982,565	-	-
Бэрх үүл ХК -**		-	-	-	-	-	941,481	-	-	-	-
Нако Түлш ХК		-	-	-	-	-	-	2,335,023	-	-	-
Шарын Гол Энержи ХХК		-	-	-	-	-	-	-	9,875	-	-
Засаглах удирдлага		-	-	-	-	-	-	4,530	477,926	65,997	2,768
Гүйцэтгэх удирдлага		-	-	-	-	-	-	-	153,775	544,141	121,357
						12,710,678	7,119,727	2,629,410	3,219,035	918,323	315,190
Охин компани:											
Нако Түлш ХК		-	181,169	26,017	-	-	-	-	2,318,446	-	-
Нагай ХХК		-	-	1,424,386	-	-	-	-	1,930	337,219	-
- * Тайлант хугацаанд Говь Кораван ХХК-аас шатахууны худалдан авалт, үндсэн хөрөнгө, алтны олборлолтын үйл ажиллагааны өртөг гэх мэт ажил гүйлгээ хийгдсэн болно.											
- ** Дээрх холбоотой талууд нь тайлант хугацаанд холбоо хамраалгүй болсон.											

“ШАРЫН ГОЛ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД

2018 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ(үргэлжлэл)

38. БОЛЗОШГҮЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Компанид ажиллаж байсан Жеймс Флорисын цалин хөлстэй холбоотой 465,331 мянган төгрөгийн нэхэмжилсэн. Анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийг 249,183 мянган төгрөгөөр хангаж шийдвэрлэсэн. Гэхдээ нэхэмжлэгч нь Улсын дээд шүүхэд гомдол гарсан ба шүүхийн эцсийн шийдвэр хараахан гараагүй байна.

39. ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант жилийн тайлагналтай нийцүүлэх үүднээс тодорхой зарим зэрэгцүүлсэн үзүүлэлтүүдийг дахин ангилсан болно.

40. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

ТУЗ-ийн 2019 оны №9 тоот тогтоолоор "Хай Би Ойл" ХХК-д төлөх 664,500 ам. долларын зээлийн үлдэгдэл, 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүртэлх хуримтлуулсан хүүгийн өглөг 170,642.79 ам.доллар нийт 835,142.79 ам.доллар буюу 2,198,705 мянган төгрөгийн өр төлбөрийг Компанийн хувьцааны арилжааны албан ёсны мэдээний сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханш болох 1,929.32 төгрөгөөр тогтоон нийт 1,139,627 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлж нэмж хувьцаа гаргах тухай шийдвэр гаргасан. Уг асуудлыг 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өдөр болон санхүүгийн тайланг бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон, томоохон өөр бусад өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.

41. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Монгол болон Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга агуулгын зөрүү гарах тохиолдолд Монгол хэл дээрх хувилбарыг баримтална.